




2025-2026

ТАЙВАНИЙГ

нэг цонхоор



БНХУ Тайваний Гадаад
Харилцааны Яамнаас
эрхлэн гаргав.






Номын хавчуурга болгон хэрэглэж болно.



2025-2026

ТАЙВАНИЙГ нэг цонхоор



БНХУ Тайваний Гадаад Харилцааны Яамнаас
эрхлэн гаргав.

2025-2026

ТАЙВАНИЙГ нэг цонхоор

БНХУ Тайваний Гадаад Харилцааны Яамнаас эмхэтгэн гаргав.
БНХУ Тайвань, Тайпэй хот 100, Жонгжен дүүрэг, Кэтагалан
өргөн чөлөө, 2 тоот
<http://www.mofa.gov.tw>

Эмхэтгэсэн: Жанет Чан

Ерөнхий редактор: Вэнди Чан

Хариуцлагатай редактор: Лью Кун-хао

Редактор: Бий Чан, Мэг Чан, Кай Генак, Тори Гервайс, Лаура
Хуан, Клер Лир

Эх бэлтгэл, дизайн: Ху Жу-юй, Чиа Чин -ан,
Лин Чэнь-жү, Лин Шинь-че

Гэрэл зургийг: Чэнь Мэй-лин, Чин Хун-хао

Орчуулж хянасан: Я.Отгонжаргал

(Тайпэйн Худалдаа, Эдийн Засгийн Улаанбаатар дахь
Төлөөлөгчийн газар)

Distributed by Taiwan Panorama Magazine

No. 2, Aiguo West Rd. Zhongzheng Dist.

Taipei City 100, ROC Taiwan

Tel: (+886) 2-2397-0633


<http://www.taiwan-panorama.com>

"Наруд Дизайн" ХХК-д хэвлэв.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Зохиогчийн зөвшөөрөлгүй хэсэгчлэн
эсвэл бүхэлд нь хуулбарлахыг хориглоно.

Холбоо барих байгууллага: БНХУ Тайваний Гадаад Харилцааны Яам

Холбоо барих утас: (+886) 2-3343-2712



Тайваний тухай товч мэдээлэл

Албан ёсны нэр	БНХУ Тайвань
Төрийн далбаа	
Үндэсний цэцэг	Чавганы цэцэг
Газар нутгийн хэмжээ (Тайвань арал болон дагуул арлууд)	36,197 км²
Хүн ам	23.4 сая (2024 оны 12-р сар)
Угсаатны бүтэц	Хань үндэстэн 94.8%, уугуул малай-полинез гаралтай иргэд 2.6%, голчлон Зүүн Өмнөд Азийн орнууд болон Хятадаас шинээр ирж суурьшсан цагаач иргэд 2.6%
Засаг захиргаа	Олон намын ардчилсан тогтолцоо
Ерөнхийлөгч	Лай Чиндэ
Нийслэл	Тайпэй хот
Томоохон хотууд	Тайпэй, Шинэ Тайпэй, Таюянь, Тайжун, Тайнань, Гаосюн хот
Үндэсний мөнгөн тэмдэгт	Шинэ тайвань доллар (NT\$ / TWD)
Хэл	Мандарин (хятад), холо, хакка, нутгийн уугуул хэл
Шашин шүтлэг	Буддизм, Даосизм, Христийн шашин, И-Куантао



Агуулга



- 01 Тайваний байгаль орчин –8
- 02 Хүмүүс –14
- 03 Түүх –18
- 04 Улс төрийн тогтолцоо –30
- 05 Гадаад харилцаа –38
- 06 Хоёр эргийн харилцаа –50
- 07 Эдийн засаг –56
- 08 Шинжлэх ухаан, технологи –66
- 09 Боловсрол –72
- 10 Соёл – 76
- 11 Хэвлэл мэдээлэл – 80
- 12 Тайваний аялал жуулчлал – 84

Дизайнер Лин Чэнь жү

Онцлох мэдээлэл

01

Тайваний Юй шань нь (Хаш уул) Зүүн Азийн ноён оргил билээ.

Тайваний газар нутгийн 20 орчим хувь нь тусгай хамгаалалтад байдаг.

Тайваний байгаль орчин

Тайвань нь Номхон далайн баруун хэсэгт Япон, Филиппиний хооронд оршдог бөгөөд Тайваний газар нутагт Пэнху, Жиньмэнь, Мазү зэрэг дагуул арлууд хамаарагдана. Тайвань арал түүний дагуул арлуудын газар нутгийн нийт хэмжээ нь 36,197 км² юм. Газар нутгийн хэмжээ нь Нидерланд Улстай ижил хэмжээтэй ч Тайваньд 23 сая гаруй хүн ам оршин суудаг тул дэлхийд хүн амын нягтрал хамгийн өндөртэй улсын тоонд орно.

Тайвань байгалийн сүр жавхлан цогцолсон газар. Нутаг дэвсгэрийн талаас илүү хувийг 3000 метрээс өндөр 268 оргил бүхий өндөр уул нурууд болон ой модоор бүрхэгдсэн бэл хормой эзэлдэг. Үндсэн арлын газрын гадаргуу нь галт уул, тэгш тал, далайн эрэг, нам дор газруудаас бүрдэнэ.

Тайвань нь төрөл бүрийн ургамал, амьтантай бөгөөд тухайлбал Тайваньд нутагшсан Формосын сика буга байдаг. (Чин Хун-хао)




Тайваний зүүн хойд зүгт орших Дяоүтай, Өмнөд Хятадын тэнгис дэх арлууд, болон Дунша (Пратас), Нанша (Спратли), Сиша (Парасель), Жунша (Маклсфилдийн эрэг) арлууд нь Тайваний газар нутагт харьяалагддаг.

Тайвань Ази тивийн зүүн эргийн халуун орны уур амьсгалын бүсээс сэрүүн уур амьсгалын бүсэд шилжих урсгалын замд байрлах тул халуун хүйтэн хосолсон өвөрмөц цаг агаартай юм. Үржил шимтэй хөрс, хур тунадас бүхий уур амьсгал нь газар тариалан эрхлэх таатай орчныг бий болгодог. Иймд Тайваньд бүх төрлийн жимс, ногоог тариалах боломжтой. Эдгээр нь

Тайваний хамгийн өндөр оргил болох Юй шань нь өвөрмөц тогтоцтой уулс бөгөөд үндэсний бэлгэ тэмдэг юм.

(Юй шань байгалийн цогцолборт газрын зөвшөөрөлтэйгээр, Зургийг Цуй Цу ши)



Тоо баримт



тус аралд аялал жуулчлал хөгжих гайхалтай нөхцөлийг бүрдүүлдэг. Өвлийн улиралд Нантоу сяний Хэхуань уулын хойд оргилд цас орохыг үзээд арлын өмнө зүгт 200 км давхин халуун орны уур амьсгалтай Пиндун саянд очиж Шүрэн хадны ойролцоо усанд сэлэх боломжтой.

Тайваний дагуул жижиг арлууд ч өөрийн гэсэн байгалийн өвөрмөц онцлог өнгө төрхтэй. Тухайлбал, Пэнху арлын босоо багана хэлбэртэй чулуун хад, Ногоон арал, Гүйшань арлын эрэг дагуу байрладаг далайн халуун рашаан зэргийг дурдаж болно.

Ургамал, амьтан

Тайваний халуун дулаан уур амьсгал, өргөн уудам газарзүйн байршил нь тус аралд ургамал, амьтны олон төрөл зүйл оршин тогтнох нөхцөлийг бий болгожээ. Тайваньд 123 зүйл хөхтөн амьтан, 758 зүйл шувуу,

117 зүйлийн хэвлээр явагч, 43 зүйл хоёр нутагтан, 404 зүйл эрвээхэй, 2975 зүйл загас байдаг. Арлын ургамлын аймагт 790 зүйлийн ойм, 5,718 зүйлийн цэцэгт ургамал, 108 зүйлийн ил үрт ургамал багтдаг. Эдгээр ургамал, амьтад байдаг экосистемийг хамгаалахын тулд Засгийн газар нийт газар нутгийн 20 орчим хувийг тусгай хамгаалалтад авсан юм. Үүнд: 9 байгалийн цогцолборт газар, 1 байгалийн унаган цогцолборт газар, тусгай Эко системийн 22 байгалийн нөөц газар, ойн нөөц бүхий 6 газар, зэрлэг ан амьтдын хоргодох 21 газар болон хээрийн ан амьтдын амьдрах таатай орчин бүхий 39 газрыг багтаасан.

Тайваний хамгийн алдартай загас бол далайд гарцгүй бүс нутагт амьдардаг Формоза хулд загас (*Oncorhynchus masou formosanus*) юм. Далайн түвшин огцом буурсан мөстлөгийн сүүлийн үед хулд загаснууд цэнгэг болон давстай усны хооронд нааш цааш нүүдэллэх боломжгүй болж, Тайваний төв хэсгийн хүйтэн уулын усанд тэр чигтээ гацаж үлдсэн гэж үздэг. Энэхүү аюулд өртсөн зүйлийг хамгаалахын тулд Формозан далайд гарцгүй загасны хоргодох газрыг Шэй-Па байгалийн цогцолборт газар дахь Дажиа голын дээд урсгалд байгуулсан.

Байгалийн үзэсгэлэнт цогцолбор газрууд




Жиньмэнь



Өмнөд
Пэнху далай



Дунша
шүрэн арал



Онцлох мэдээлэл

02

Тайваньд албан ёсны 16 уугуул омгийнхон байдаг.

Хятад болон Зүүн өмнөд Азиас 600 мянга гаруй иргэд Тайваньд цагаачлан оршин сууж байна.

Хүн амын 95 гаруй хувийг Хань үндэстэн эзэлдэг ч Тайвань өөрийн гэсэн өвөрмөц, соёл уламжлалтай орон юм. XVII зуунаас эхлэн цагаачлан ирсэн хятад иргэдийн давлагаа нь харилцан адилгүй хэл яриа, ёс заншлыг Тайваньд тээн авчирчээ. Тэд Тайваньд урт удаан хугацаанд оршин сууж ирсэн уугуул малай-полинез гаралтай овог аймгуудын хамтаар суурьшсан бөгөөд эдгээр овог аймаг бүр өөрийн гэсэн онцлог зан заншил, нийгмийн бүтэцтэй юм.


ХҮМҮҮС

Хуалянь хотын орон нутгийн уугуул "Алефис" хамтлаг 2024 оны Үндэсний баярын үеэр бүжиглэсэн уламжлалт бүжиг. (Чин Хун-хао)




Тоо баримт

Тайваний хүн ам: **23,400,220** (2024 оны 12-р сар)



Хүн амын бүтэц:

- 0-17 нас: 14.28%
- 18-64 нас: 66.53%
- 65-аас дээш нас: 19.18%



Угсаатан:

- Хань үндэстэн: 94.8%
- Нутгийн уугуул: 2.6%
- Шинээр ирж суурьшсан цагаач иргэд: 2.6%

Төрөлт (2024): **5.76** (1,000 хүн тутамд)

Нас баралт (2024): **8.63** (1,000 хүн тутамд)

Хүн амын дундаж наслалт (2024): **80.23** наслалт



Эрэгтэй:

76.94 наслалт



Эмэгтэй:

83.74 наслалт



Сүүлийн жилүүдэд Хятад болон Зүүн өмнөд Азиас шинээр ирж суурьшиж буй цагаач иргэдийн урсгал нэмэгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар шинэ цагаачдын тоо 6000 мянга давжээ.

Сүүлийн үед Тайваньчууд хүн амын 2.6%-ийг бүрдүүлэгч, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн австронез хэлээр ярьдаг нутгийн уугуул 16 омгийн хэл, соёл уламжлалд ихээхэн ач холбогдол өгч, хүндэтгэн үзэх болсон. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд тэдгээр омгуудын хэл, соёлыг сэргээхийн төлөө хүчин чармайлт гаргаж буйн нэг жишээ нь Тайваний уугуул үндэстний телевизийн сувгийг бий болгож, нутгийн уугуул үндэстний эрх ашгийг хамгаалсан хуулийг баталсан явдал юм.

Тайваний соёлын чиг хандлагын энэхүү нэгдэл, харилцан хамаарал бүхий өвөрмөц байдал нь дэлхийн өнцөг булан бүрийн соёлын элементүүдийг өөртөө шингээн, алс ирээдүйг харсан нийгэм болон өөрчлөгдөхөд нөлөөлсөн юм.

Онцлох мэдээлэл

03

XVII зууны эхээр Голланд, Испаниас цагаачлан ирсэн иргэд Тайваньд суурин амьдралыг бий болгожээ.

1940-өөд оны сүүлч, 1950-аад оны эхээр нийт 1.2 сая орчим иргэд Хятадын эх газраас Бүгд Найрамдах Хятад Улсын Засгийн газрыг шилжүүлж Тайваньд ирж суурьшсан.

Бүгд Найрамдах Хятад Улс нь 1912 онд Хятадын эх газарт байгуулагдсан. 1895 оны Шимоносэкигийн гэрээгээр Манж Чин Улсын Засгийн Газар Тайванийг Японд шилжүүлснээр Тайвань Японы эзэмшил нутаг болсон юм. 1945 онд Дэлхийн II дайнд Япон Улс ялагдсаны дараа Тайвань БНХУ-ын мэдэлд шилжив.

1949 онд БНХУ-ын Засгийн газар дотоодын иргэний дайны үед Хятадын Коммунист Намтай тэмцэж байхдаа Тайваньд шилжин суурьшсан. Үүнээс хойш БНХУ нь Тайваний гол арал болон дагуул арлуудыг захирч ирсэн бөгөөд ингэснээр Тайвань болон Хятад Улс өөр өөрийн засаг захиргаатай, тус тусдаа эрх барьж ирсэн. Бүгд Найрамдах Хятад Ард Улс хэзээ ч БНХУ-ын захиргаанд байгаа Тайвань болон бусад арлуудыг бүрэн эрхийнхээ дор захирч байгаагүй.

Түүх

Голландчуудын суурилуулсан цутгамал төмөр ханын бэхэлгээний мөр өнөөг хүртэл XVII зууны үеийн Тайнань хотын өмнөд хэсэгт орших Зеландия цайзын хананд үлдсэн байдаг. (Чэнь Мэй-лин)



Түүхэн он цагийн товчоон

Тайвань нь Малай-Полинез гаралтай иргэдийн өлгий нутаг бөгөөд энэхүү түүхэн он цагийн товчоонд зөвхөн сүүлийн 400 орчим жилийн түүхийг хамруулсан болно.

1500 - аад он Анх Тайванийг дайран өнгөрч байсан европын далайчид уг арлыг “Илха Формоза” буюу “Үзэсгэлэнтэй арал” гэж тэмдэглэсэн гэж үздэг.

Тайвань арал дээр Хятадаас цөөн тооны наймаачид, загасчид, далайн дээрэмчид ирдэг байжээ.

1624 Голландын Зүүн Энэтхэгийн компани Тайваний баруун өмнөд хэсэгт тосгон байгуулж, уугуул иргэдийн тариалан эрхлэх арга технологийг сайжруулж, будаа, чихрийн нишингэ тариалахад хятад иргэдийг хөлслөн ажиллуулах болжээ.

1626 Испанийн адал явдал хайгчид Тайваний хойд хэсэгт суурин газар байгуулсан боловч 1642 онд Голландчуудад хөөгджээ.

1662 Манжийн байлдан дагуулалтаас (1368-1644) Мин гүрний албатууд дайжин зугтаж Тайваний арал дээр очиж байжээ.

Мин гүрэнд үнэнч албатууд Жэн Чэнгуний удирдлага дор Голландчуудыг хөөн гаргаж, арлыг эзлэн авав.

1683 Манж Чин гүрний (1644-1912) цэргийн арми Тайваний баруун болон хойд эргийг эзлэв.

1885 Манж Чин гүрэн Тайванийг өөрийн нэг муж хэмээн зарлав.

1895 Манж Чин гүрэн Японтой (1894-1895) дайтаж ялагдал хүлээсний дараа Чин Улсын Засгийн Газар Шимоносэкигийн гэрээнд гарын үсэг зурснаар Тайваний арал Японы мэдэлд шилжжээ.

1911-1912 Хятадын хувьсгалчид Манж Чин гүрний ноёрхлыг түлхэн унагаж, Бүгд Найрамдах Хятад Улсыг байгуулав.

1943 Дэлхийн II дайны үеэр БНХУ-ын удирдагч Чан Кайши Каир хотноо АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Рузвельт, Их Британийн Ерөнхий сайд Уинстон Черчилль нартай уулзсаны дараа Каирын тунхагт “... Тайвань болон Пэнху арлуудыг БНХУ-д эргүүлэн өгөх нь зүйтэй...” хэмээн мэдэгдсэн байна.

1945 БНХУ, Их Британи, АНУ хамтран Потсдамын тунхаг гаргаж, Япон Улсыг болзолгүйгээр үг дуугүй бууж өгч, Каирын тунхгийг хэрэгжүүлэхийг шаардав.

Дэлхийн II дайны дараа БНХУ-ын Засгийн газрын төлөөлөгч Японы арми Тайваньд бууж өгсөн болохыг хүлээн зөвшөөрөв. Тайвань мужийн захирагч Чэнь И Япон Улсаас Тайваний асуудлыг ерөнхийлөн захирагчид хандан албан бичиг илгээж, Би Тайваний захирагчийн хувьд ...

Тайваний нутаг дэвсгэр, хүн ам, засаг захиргаа, улс төр, эдийн засаг, соёлын байгууламж, эд хөрөнгийн (Пэнху арлуудыг багтаасан) хууль ёсны эрхээ сэргээж байна хэмээн мэдэгдэв.

1947 БНХУ-ын Үндсэн хуулийг 1-р сарын 1-нд баталж, 12-р сарын 25-нд хүчин төгөлдөр мөрдөхөөр төлөвлөсөн боловч 2 дугаар сарын 28-нд Тайваньд эсэргүүцлийн хөдөлгөөн гарсан тул уг хөдөлгөөнийг дарахын тулд 3 дугаар сараас эхлэн Хятадын эх газраас арлын зүг цэргүүдийг тасралтгүй илгээж байжээ.

1948 Хятадад Гоминдан нам тэргүүлсэн БНХУ-ын Засгийн газар болон Хятадын Коммунист намын (ХКН) хооронд иргэний дайн өрнөж, коммунистуудын эсэргүүцлийг дарахын тулд "Түр цагийн хууль"-ийг баталсан бөгөөд энэхүү хууль нь БНХУ-ын Үндсэн хуулийг давж гарсан шинжтэй болж Ерөнхийлөгчийн эрх мэдлийг илүү хүчирхэгжүүлсэн юм.

Энэхүү байдал нь олон мянган энгийн гэмгүй иргэдийн хэлмэгдүүлсэн цагаан терроризмыг эхлүүлж, 1991 онд тус хуулийг цуцлах хүртэл үргэлжилсэн юм.

1949 БНХУ-ын Засгийн газар Тайваньд шилжсэний дараа Хятадын эх газраас 1.2 сая гаруй хүн Тайваньд шилжин суурьшжээ.

10 дугаар сарын 25-ны өдөр Тайваний баруун хойд Жиньмэнь арлын Гу Нинтоу гэдэг газар болсон тулалдаанд БНХУ-ын арми ХКН-ын цэргийг ялав.

Тайвань 1987 он хүртэл байнгын байлдааны бэлэн байдалтай оршин тогтножээ.

1952 1951 онд НҮБ болон Японы нэрийн өмнөөс холбоотны 48 гүрэн Сан Францискогийн энх тайвны гэрээнд гарын үсэг зурсны дараа БНХУ нь Япон Улстай Тайпэй зочид буудалд энхийн гэрээ байгуулснаар хоёр талын дайны байдал албан ёсоор эцэс болов. Сан Францискогийн гэрээний 2 дугаар зүйлд заасны дагуу Япон Улс Тайвань, Пэнху (Пэнху арлууд), Наньшагийн бүлэг арлууд, Сишагийн бүлэг арлуудад тогтоосон эрх мэдлээсээ бүр мөсөн татгалзсан юм. Ийнхүү 1941 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс өмнө Хятад, Японы хооронд байгуулсан бүх гэрээ, конвенц, хэлэлцээрүүд хүчингүй болсон билээ.



Өмнөд боомт хот дахь Гаосюн усан онгоцны үйлдвэр 1973 онд ашиглалтад оржээ. (Тан Кэн-ли)

1954 Вашингтон хотод БНХУ болон АНУ батлан хамгаалах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав.

1958 8 дугаар сарын 23-ны өдөр Жиньмэнь аралд БНХУ-ын гарнизон Коммунист Хятадын армитай 40 гаруй хоног тулалдав.

1966 Тайваний өмнөд хэсгийн Гаосюн хотод экспортын анхны бүтээгдэхүүн боловсруулах бүсийг байгуулав. Энэхүү бүсийг байгуулснаар Тайвань хөгжингүй орон болон хөгжиж, бусад улс орнуудад үлгэр жишээ болсон юм.

1968 Тухайн үед дэлхий дахинд зөвхөн 9 улс есөн жилийн суурь боловсролын тогтолцоог хэрэгжүүлж байсан бөгөөд Тайвань энэ системийг нэвтрүүлсэн байна.

1971	10 дугаар сарын 25-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблей НҮБ-ын 2758 тоот тогтоолыг баталж, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ыг дэлхий дахинаа олон улсын харилцаан дахь Хятадын цорын ганц хууль ёсны төлөөлөгч хэмээн хүлээн зөвшөөрсөн тул БНХУ НҮБ-аас гарсан юм.
1979	Гаосюн хотод түүхэнд “Гаосюны хэрэг” хэмээн тэмдэглэгдсэн жагсаалыг зохион байгуулсан ардчилсан үзэлтнүүдийг баривчилж хорьсон нь Тайваний Ардчилсан Дэвшилтэт нам байгуулагдах суурийг тавьжээ. Уг нам 1986 онд албан ёсоор байгуулагджээ.
1987	1949 оноос хойш хүчин төгөлдөр мөрдөгдсөн “Түр цагийн хууль”-ийг цуцалснаар улс төрийн шинэ нам байгуулах, хэвлэн нийтлэх эрхтэй болов. Ардчилал хүчээ авснаар хоёр эргийн иргэд харилцах боломжтой болов. Хоёр талын ард түмний уулзалт, соёлын солилцоо эхлэв.
1991	Коммунистуудын эсрэг бүх нийтийн дайчилгааны үеэр мөрдөгдөж байсан түр заалтуудыг цуцлав. 1991-1992 онд Хууль тогтоох байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийг дахин бүрэн бүрэлдэхүүнээр нь сонгож, Тайваний ард түмнийг бүрэн төлөөлөлтэй болгов. БНХУ Тайвань 1991-2005 оныг хүртэл Үндсэн хуулиа долоон үе шаттайгаар шинэчилсэн. Тайвань Ази, Номхон Далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллагын гишүүн болжээ.
1992	Хоёр эргийн Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчид Хонконгт анх удаа уулзалт хийсэн бөгөөд үүний дараа хэлэлцээр хийж олон талт хамтарсан мэдэгдэл гаргаж, харилцан ойлголцолд хүрэв.

1995	Үндэсний эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр хэрэгжиж эхлэв. 2 сарын 28-ны хэрэг явдлыг нэхэн шийдвэрлэх болон түүнд нөхөн олгох хуулийг хэрэгжүүлж эхлэв.
1996	БНХУ Тайваний Ерөнхийлөгчийн анхны чөлөөт сонгуулиар Гоминдан намаас нэр дэвшигч Ли Дэньхуй 54 хувийн санал авснаар ялсан юм.
2000	Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан Дэвшилтэт нам ялж, нэр дэвшигч Чэнь Шүйбянь, Лу Сиулиэнь нар Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчөөр сонгогдсоноор 50 гаруй жил засгийн эрхийг дангаар барьсан Гоминданы ноёрхол эцэс болов. Энэ нь БНХУ Тайваньд тус орны гүйцэтгэх засаглалын эрх анх удаа өөр улс төрийн намд шилжсэн түүхэн үйл явдал болсон юм.
2002	Тайвань Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэв. Зэвсэгт хүчний бодлого боловсруулах, командлалыг нэгтгэх зарчимд суурилсан Үндэсний батлан хамгаалах хоёр хууль 3 дугаар сарын 1-ний өдрөөс албан ёсоор мөрдөгдөж эхлэв. “Зэвсэгт хүчнийг үндэсний болгох” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Батлан Хамгаалах Яамны харьяа байгууллагууд шинээр байгуулагдаж, зохицуулалт хийгдэв.
2003	Хууль тогтоох Юань “Ард нийтийн санал асуулгын тухай хууль”-ийг баталж, иргэд орон нутгийн болон улсын чанартай асуудлаар шууд санал өгөх эрх зүйн үндэс бүрдэв.

2004 Анхны санал асуулга гурав дахь удаагийн Ерөнхийлөгчийн сонгуультай зэрэг явагдсан бөгөөд Чэнь Ерөнхийлөгч, Лу Дэд ерөнхийлөгч нар дахин сонгогдов.

2005 Хууль тогтоох Юань Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах багц хуулийг баталж, Парламентын гишүүдийн суудлын тоог 225-аас 113 болгон бууруулж, хууль тогтоох байгууллагын сонгуульд нэг тойрогт хоёр санал өгөх тогтолцоог нэвтрүүлэв.

2008 Гоминдан намаас нэр дэвшигч Ма Инжью, Винсент Сиев нар 58 хувийн саналыг авч БНХУ Тайваний Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчөөр сонгогдсоноор Тайваньд Засгийн газрын гүйцэтгэх эрх мэдлийг улс төрийн намуудын хооронд хоёр дахь удаагаа шилжүүлсэн үйл явдал болов.

2009 Тайвань ДЭМБ-ын нэгдсэн чуулганд ажиглагчаар оролцсон нь Тайвань 1971 онд НҮБ-аас гарснаас хойш анх удаа НҮБ-ын үйл ажиллагаанд оролцсон тохиолдол байв.

2010 БНХУ Тайвань болон БНХАУ “Хоёр эргийн эдийн засгийн хамтын ажиллагааны үндсэн хэлэлцээр”-т гарын үсэг зурж, хоёр эргийн эдийн засаг, худалдааны харилцаанд зохицуулалт хийв.

2011 Бүгд Найрамдах Хятад Улс байгуулагдсаны 100 жилийн ойг Тайваньд тэмдэглэн өнгөрүүлэв.

2013 Тайвань Шинэ Зеландтай эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ, Сингапуртай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт гарын үсэг зурав.

Тайвань олон улсын иргэний нисэхийн байгууллагын ассамблейн 38 дугаар чуулганд тус зөвлөлийн даргын урилгаар зочноор оролцов.

2014 Хятадын эх газрын хэрэг эрхлэх хорооны сайд Ван Ючи 2 дугаар сард Наньжинд Хятадын Тайваний хэрэг эрхлэх газрын дарга Жан Жижүнтэй албан ёсны уулзалт хийсэн явдал нь Засгийн газрын харьяа байгууллагуудын тэргүүн нар хоёр эргийн харилцааны асуудлаар ярилцсан анхны албан ёсны уулзалт болсон юм.

Тайваний оюутан залуучууд, ард иргэдийн хамтарсан “Наранцэцэгийн хөдөлгөөн”-ий жагсагчид хоёр эрэг дамнасан худалдаа үйлчилгээний гэрээ байгуулахыг эсэргүүцэж, Хууль тогтоох Юанийг эзлэн авч суулт хийснээр уг хэлэлцээрийг таслан зогсоов.

“1-д 9” хэмээн нэрлэгддэг орон нутгийн сонгуулиар улсын хэмжээнд есөн ангиллын нутгийн удирдлагын төлөөлөгчдөөр 11130 нэр дэвшигч сонгогдсон байна.

2015 Ерөнхийлөгч Ма болон Хятадын дарга Ши Жиньпин нар 11 дүгээр сард Сингапурт уулзсан нь хоёр тал сүүлийн 66 жилийн хугацаанд анх удаа дээд түвшний уулзалт хийсэн түүхэн үйл явдал болов.

Тайвань Дэлхийн худалдааны байгууллагын “Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр”-т гарын үсэг зурж, тус байгууллагад уг хэлэлцээрийг хүлээн зөвшөөрсөн тухай бичгийг хүргүүлэв.

2016 Ардчилсан Дэвшилтэт намын дарга Цай Инвэнь, академич Чэнь Жяньрэнь нар Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчөөр сонгогдов. Ардчилсан Дэвшилтэт нам нь парламент дахь 113 суудлын 68-ыг авснаар Хууль тогтоох Юанд анх удаа олонх болсон.

Ерөнхийлөгч Цай Инвэнь Засгийн газрын нэрийн өмнөөс Тайваний уугуул ард түмэнд хандан олон зуун жилийн турш зүй бус харьцаж зовлон зүдгүүр амсуулж байсны хариуд албан ёсоор уучлалт гуйв.

2017 Тайваньд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн 16 уугуул омгийн төрөлх хэлийг хамгаалах, сурталчлах зорилгоор “Уугуул иргэдийн хэл, соёлыг хөгжүүлэх тухай хууль”-ийг батлав.

Тайпэй хотноо зуны Универсад наадмыг зохион байгуулсан.

Тайвань анх удаа дотоодод үйлдвэрлэсэн хэт өндөр нарийвчлалтай дэлхийг ажиглах Формоза-V хиймэл дагуулыг хөөргөв.

2018 Тайваний Шилжилтийн үеийн шударга ёсны зөвлөл 5 дугаар сарын 31-ний өдөр байгуулагдав. Ерөнхийлөгч Цай тус оронд 1949-1991 онд цагаан терроризмын үеэр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах шийдвэр гаргаж, хэлмэгдсэн иргэдээс албан ёсоор уучлалт гуйв.

2019 Ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрч тусгай хууль баталснаар Тайвань ЛГБТ холбоог зөвшөөрсөн Азийн анхны орон болов.

2020 2020 оны Ерөнхийлөгчийн сонгуульд эрх баригч Ардчилсан Дэвшилтэт намаас нэр дэвшигч Цай Инвэнь, Лай Чиндэ нар ялалт байгуулав. Ардчилсан Дэвшилтэт нам Хууль тогтоох Юаньд олонх хэвээр үлдэв.

2022 Үндэсний Батлан Хамгаалах Яамнаас 1 дүгээр сарын 1-ний өдөр цэргийн нөөцийг ашиглах, холбогдох бүх үйл ажиллагаанд тусалж дэмжих зорилгоор Үндэсний батлан хамгаалах дайчилгааны газрыг байгуулав.

Холбогдох салбаруудыг хөгжүүлэх, дижитал засаглал, дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийг зохицуулах зорилгоор Цахим Хөгжлийн Яамыг 8 дугаар сарын 27-ны өдөр байгуулав.

2024 Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчөөр Ардчилсан Дэвшилтэт намын Лай Чиндэ, Шиао Мэй чин нар сонгогдов. Энэ нь 1996 онд болсон Тайваний Ерөнхийлөгчийн шууд сонгуулиас хойш нэг улс төрийн нам гурван удаа дараалан ялалт байгуулсан анхны тохиолдол юм.

2025 АНУ-ын Төлөөлөгчдийн танхим 5 дугаар сарын 5-нд “Тайваний олон улсын эв нэгдлийн тухай хууль”-ийг баталж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2758 дугаар тогтоол нь Тайвань болон түүний ард түмний НҮБ болон түүнд харьяалагдах байгууллагуудад төлөөлөлтэй байх асуудлыг хөндөөгүй болохыг мэдэгджээ. Түүнчлэн уг хууль нь Тайваний ард түмний зөвшөөрөлгүйгээр Тайваний статусыг өөрчлөх аливаа санаачилгад АНУ эсэргүүцлээ илэрхийлж буйгаа дахин нотолж байна.

Шинэ Тайпэй хотын “Шисаньхангийн Археологийн музей”-д Тайваний эртний түүхийг онцлон харуулсан үзэсгэлэн гарч байна. (Пан Жя-шань)



Онцлох мэдээлэл

04

Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчийг дөрвөн жил тутамд ард иргэдийн шууд сонгуулиар сонгодог.

Тайваний Хууль тогтоох байгууллагын сонгуульд оролцохдоо сонгогчид харьяа дүүрэгт нэг, том тойрогт өөр нэг санал тус тус өгдөг.

Улс төрийн ТОГТЛОЦОО

1947 оны 1 дүгээр сарын 1-нд батлагдсан Үндсэн хууль нь Тайваньд цэргийн хяналтыг цуцалсан 1987 оноос хойш л ардчилсан засаглал ба эрх зүйт төрийн үндэс суурь болох үүргээ гүйцэтгэж эхэлсэн. 1991, 1992, 1994, 1997, 1999, 2000, 2005 онуудад Үндсэн хуулиа шинэчлэн найруулж, өөрийн орны онцлог, одоогийн бодит нөхцөл байдалд илүү нийцүүлжээ.

Эдгээр нэмэлт өөрчлөлтийн нэг чухал үр дүн нь 1991 оноос хойш Засгийн газар нь зөвхөн өөрийн мэдэлд байгаа бүс нутагт засаг захиргааны эрхээ хэрэгжүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрсөн явдал юм.

БНХУ, Тайваний Агаарын хүчний "Аянгын барсууд" нислэгийн баг 10-р сарын 10-нд тус улсын 113 дахь Үндэсний баярын өдөрт зориулан Ерөнхийлөгчийн ордны дээгүүр нислэгийн үзүүлбэр үзүүллээ.
(Чин Хун-хао)



Тиймээс ерөнхийлөгч, хууль тогтоогчид зөвхөн тухайн бүс нутгийн ард түмнээс сонгогдох бөгөөд тэдний өмнө хариуцлага хүлээдэг.

2005 оны 6 дугаар сард батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Хууль тогтоох Юанийн суудлын тоог 225-аас 113 болгон хоёр дахин бууруулж, хууль тогтоогчдын бүрэн эрхийн хугацааг гурваас дөрвөн жил болгон нэмэгдүүлсэн. Хууль тогтоох Юанийн сонгуулийн шинэ тогтолцооны дагуу сонгуулийн тойрог бүр нэг мандаттай байна. Сонгогч бүр хоёр санал өгөх бөгөөд нэг нь дүүрэгт нөгөө нь том тойрогт саналаа өгнө. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлах эсэхийг ард нийтийн санал асуулгаар шийдвэрлэнэ.

Бүх шатны засаг захиргааны байгууллагууд

Төв Засгийн газар нь Ерөнхийлөгчийн Тамгын газар болон Засгийн газрын таван юаниас бүрдэнэ. Одоогийн байдлаар орон нутгийн засаг захиргаанд мужуудтай адил шаталсан статустай шууд төвд харьяалагдах 6 хот, 13 сянь, сяньтай ижил түвшний 3 өөртөө засах хот багтдаг. 2014 оноос эхлэн Тайваний бүх хот, сяньд орон нутгийн засаг захиргааны бүх удирдлага, төлөөлөгчдийг дөрвөн жил тутамд нэгэн зэрэг сонгодог болсон. Нэмж дурдахад 198 сяний захиргаанд харьяалагддаг тосгон, хотууд, мөн 170 дүүрэг, үүнд уугуул иргэдийн уулархаг нутгийн 6 автономит дүүрэг болон шууд захирагдах хотууд багтдаг.

Төв Засгийн газрын таван юань

Гүйцэтгэх Юань

Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх

Хууль тогтоох Юань

Хууль тогтоомжийг батлах, бодлогын асуудлаар сонсгол явуулах, төсвийн хуулийн төсөл, Засгийн газрын үйл ажиллагааг хянах

Шалгалтын Юань

Төрийн албан хаагчдаас шалгалт авах, хянах


Шүүх Юань

Улсын хэмжээнд Шүүхийн системийг хариуцах

Хяналтын Юань


Албан тушаалтнуудыг хянах, хариуцлага хүлээлгэх, төрийн байгууллагуудад аудит шалгалт хийх

Орон нутгийн засаг захиргааны нэгж




Тусгай өөртөө засах хотууд нь төв Засгийн газрын шууд харьяалалд багтдаг дээд түвшний захиргааны байгууллагууд юм. Эдгээр хотууд бүс нутгийн хөгжлийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ

Лиенчян сянь



Жиньмэнь сянь



статус нь Засгийн газрын санхүүжилтийг илүү хэмжээгээр авах, нэмэлт агентлаг байгуулах болон илүү олон төрийн албан хаагч ажиллуулах боломжийг олгодог. Төв Засгийн газарт шууд харьяалагдах

хотуудаас хүн амын тоогоор Шинэ Тайпэй тэргүүлж, Тайжун, Каосюн, Тайпэй, Таоюань, Тайнань хотууд удаалдаг.

Ерөнхийлөгч ба Ерөнхий сайд

Сонгууль явуулж санал хураах зарчмаар Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчийг дөрвөн жилийн хугацаатай сонгодог бөгөөд нэг удаа улираан сонгож болдог. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч. Эх орноо гадаад улс оронд төлөөлөхөөс гадна Засгийн газрын дөрвөн үндсэн салбарын тэргүүнийг томилох бүрэн эрхтэй. Үүнд Засгийн газрын тэргүүн болох Ерөнхий сайд багтдаг бөгөөд тэрээр Засгийн газрыг удирдаж, үйл ажиллагаагаа тогтмол хугацаанд хууль тогтоох байгууллага (эсвэл юань)-д тайлагнах үүрэгтэй. Засгийн газрын зөвлөл нь Ерөнхий сайдын томилсон Засгийн газрын харьяа яам, хороо, агентлагуудын удирдлагуудаас бүрддэг. Удирдлагын гүйцэтгэлийг сайжруулах үүднээс Засгийн газрын бүтцийг шинэчилж, танхимын зэрэглэлтэй байгууллагуудын тоог 37 байсныг 30 болгож цомхотгожээ.

2012 оноос эхэлсэн уг шинэчлэлтийн дараа Засгийн газар 15 яам, 9 зөвлөл консул, 3 бие даасан агентлаг болон бусад 4 байгууллагуудаас бүрдэв. БНХУ-ын Үндсэн хуулийн дагуу Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг, Ерөнхий сайд яамдын сайдуудыг томилоход хуульчлах шаардлагагүй байдаг.

Хяналтын Юань, Шалгалтын Юаний тэргүүн болон Шүүх Юаний тэргүүнийг Хууль тогтоох Юань томилно. Харин хууль тогтоогчид Хууль тогтоох байгууллагын

тэргүүн эсвэл спикерийг тэдгээрийн зэрэг дэвээс нь шалтгаалж сонгодог.

Улс төрийн намууд

Ерөнхийлөгчийн Засгийн газрын үйл ажиллагаанд үзүүлж буй үүргийг үндэслэн “Эрх баригч нам”-ыг Ерөнхийлөгчийн харьяалагдаж буй намаар тодорхойлно. 2000 он хүртэл Гоминдан нам тасралтгүй 50 гаруй жил Засгийн эрхийг барьсан бөгөөд 2000, 2004 онд Ардчилсан Дэвшилтэт нам ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулав. 2008, 2012 оны сонгуульд Гоминдан нам ялсан бол 2016, 2020, 2024 онуудад явагдсан Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан Дэвшилтэт нам дараалан ялалт байгуулсан нь Тайваньд ардчилал хөгжсөнөөс хойш анх удаа улс төрийн нам гурван удаа дараалан ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан явдал боллоо. 2024 оны 1-р сард болсон Парламентын сонгуульд нийт 113 суудлаас Гоминдан нам 52 суудал эзэлсэн бол Ардчилсан Дэвшилтэт нам 51 суудал, Тайваний Ардын нам 8 суудал, бусад бие даан нэр дэвшигч 2 суудал тус бүр авчээ.

Онцлох мэдээлэл

05

БНХУ Тайваний паспорт эзэмшигч дэлхийн 173 орон, бүсд визгүй зорчих, дамжин өнгөрөх виз болон цахим визний эрхийг эдэлдэг.

Тайвань АНУ-тай дипломат харилцаагүй ч АНУ-ын визний хөнгөлөлтийн хөтөлбөрт багтдаг цорын ганц улс юм.

Гадаад харилцаа

БНХУ Тайвань нь бие даасан улсын хувьд өөрийн улсын батлан хамгаалах, гадаад харилцаагаа өөрөө хариуцдаг. БНХУ-ын Үндсэн хуулийн дагуу тус улс нь бусад улстай сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэх, олон улсын гэрээ хэлэлцээр болон НҮБ-ын дүрмийг хүндэтгэх зэрэг олон улсын хамтын ажиллагааг дэмжих, олон улсын шударга ёсыг сахин хамгаалж, дэлхийн энх тайвныг ханган ажиллах зорилготой байдаг. Тус улсын гадаад бодлогын туйлын зорилго нь улс үндэстнээ хамгаалах, улс орны урт хугацааны хөгжлийн таатай орчныг бий болгоход оршино.

Ерөнхийлөгч Лай Чин-дэгийн үнэ цэнийн зарчимд суурилсан дипломат харилцааны үзэл баримтлал болон Тайванийг дэлхийн эдийн засгийн хүчирхэг улс болгох

Ерөнхийлөгч Лай Чиндэ Тайпэй хот дахь Ерөнхийлөгчийн ордонд Гватемалын Ерөнхийлөгч Бернардо Аревалог хүлээн авч уулзав.
(Ерөнхийлөгчийн ордны мэдээ)



алсын хараанд тулгуурлан Тайвань нэгдсэн дипломат бодлого хэрэгжүүлдэг. Ардчилал, энх тайван, хөгжил цэцэглэлтийн гурван тулгуур баганын дээр үндэслэн Тайвань хамтын ажиллагааг өргөжүүлж, түншлэлийг гүнзгийрүүлснээр харилцан ашиг хүртэх, элбэг хангалуун байдлыг дипломат холбоотон болон ижил үнэт зүйлтэй орнуудтай хуваалцаж байна.

Өмнөд рүү чиглэсэн шинэ бодлогын дагуу Тайвань Зүүн өмнөд Азийн орнуудын холбооны гишүүн 10 орон, Өмнөд Азийн 6 орон, Австрали, Шинэ Зеланд зэрэг улсуудтай бодит харилцаа холбоогоо сайжруулахаар ажиллаж байна. Үүний урт хугацааны зорилго нь харилцан ашигтай байхад үндэслэн хамтын ажиллагааны шинэ хэв маягийг бий болгоход орших юм.

Тайвань нь дипломат холбоотон орнуудтай албан ёсны харилцаатай бөгөөд Австрали, Канад, Япон, Шинэ Зеланд, Их Британи, АНУ, Европын Холбооны болон түүний гишүүн улс орнуудтай бодит харилцаатай байдаг.

Олон улсын оролцоо

Тайвань Дэлхийн Худалдааны Байгууллага, Ази Номхон Далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Дэлхийн Амьтны Эрүүл Мэндийн Байгууллага, Азийн Хөгжлийн Банк болон Төв Америкийн Эдийн Засгийн Интеграцлалын Банк зэрэг 45 гаруй Засгийн газар хоорондын байгууллага ба тэдгээрийн харьяа байгууллагуудад бүрэн эрхт гишүүнчлэлтэй байдаг. Түүнчлэн Европын Сэргээн Босголтын Хөгжлийн Банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжил ба Төв Америкийн интеграцлалын системийн хороо зэрэг 30 олон улсын засгийн газрын байгууллага болон харьяа байгууллагуудад ажиглагчийн байр суурь эсвэл өөр статустай байдаг. Тайваний хөрөнгийн зах зээл, Ази дахь чухал байр суурийг нь харгалзан, Төв Америкийн Эдийн Засгийн Интеграцлалын банк 2021 оны 7 дугаар сарын 6-нд Тайваньд салбараа нээсэн нь Төв Америкаас гадаадад нээгдэж буй анхны салбар юм.

Тайвань өөрийн бие даасан байдал, нэр төрийг хадгалж ард түмний аж амьдралыг сайжруулахын зэрэгцээ олон улсын байгууллагуудтай ажил үүрэг мэргэжлийн түвшинд хамтран ажиллаж хувь нэмрээ оруулахыг хичээж байна. Үүний тулд ДЭМБ, Олон улсын Иргэний Нисэхийн байгууллага, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага зэрэг Засгийн газрын оролцоотой байгууллагуудтай хамтран ажиллаж хүн төрөлхтний сайн сайхны төлөө өөрийн хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж хичээсний үр дүнд дипломат болон сайн харилцаатай улс орнуудын дэмжлэгийг авсан юм.

Хүчирхэг гадаад харилцаа


2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 173 улс орон БНХУ Тайванийн паспорт эзэмшигчдэд визгүй зорчих, дамжин өнгөрөх виз эсвэл цахим визний эрх олгоод байна. Мөн Тайвань 17 улстай амралтаар ажиллах гэрээ байгуулсан.

Тайвань АНУ-тай албан ёсны дипломат харилцаагүй ч визний хөнгөлөлтийн хөтөлбөрт багтдаг цорын ганц орон бөгөөд уг хөнгөлөлтөд 40 улс хамрагддаг ба үүгээрээ хоёр талын харилцааг онцгойлон авч үзэж буйг илэрхийлсэн хэрэг юм. 1979 онд АНУ-ын Конгрессоос баталсан Тайваний харилцааны тухай хууль нь албан ёсны дипломат харилцаа тогтоогоогүй ч хоёр улсын хамтын ажиллагааны бат бэх суурь болж өгсөн. Мөн АНУ-ын зүгээс Тайваний харилцааны тухай хууль болон зургаан баталгааны дагуу Тайваньд өгсөн аюулгүй байдлын амлалтаа биелүүлж, удаа дараа нотлон харуулсан. 2018 онд Тайваний аялал жуулчлалын тухай хуулийг АНУ-ын Конгресс санал нэгтэй баталсан ба тухайн үеийн Ерөнхийлөгч Доналд Ж.Трамп гарын үсэг зурсан юм. Энэхүү хууль тогтоомж нь хоёр талын бүх шатны албан тушаалтнуудыг өөр хоорондоо айлчлах боломжоор хангаж өгсөн нь АНУ-ын Засгийн газрын Гүйцэтгэх болон Хууль тогтоох байгууллагын зүгээс Тайванийг хүчтэй

дэмжиж байгааг харуулж байна. 2020 онд Тайваний холбоотнуудын олон улсын хамгаалалт, сайжруулалтын санаачилгын тухай хуулийг (Тайпэйгийн хууль) АНУ-ын Конгресс баталж, хууль тогтоомжид гарын үсэг зурснаар АНУ дэлхий дахины Тайваний дипломат холбоотнууд болон олон улсын байгууллага дахь Тайваний оролцоог дэмжиж буйгаа илэрхийлсэн юм. 2021 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байдены засаг захиргаа нь тус улсын Тайваний талаарх амлалтаа дахин биелүүлж, АНУ-ын Засгийн газар Тайваньтай хамтран ажиллах шинэ удирдамжийг гаргаж, оролцоог нэмэгдүүлэв.

Үүний дараа АНУ-ын Конгресс 2023 болон 2024 оны Үндэсний батлан хамгаалах эрх зүйн актыг баталж, улмаар хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Энэхүү хуулийн төсөл нь Тайваний өөрийгөө хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад туслахад чиглэсэн юм. Мөн Тайвань, АНУ нь хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр хоёр орны түншлэл дэлхийн хамтын ажиллагааны нэг хэсэг болон өргөжиж байна.

2025 оны 1 дүгээр сард шинэ Трампын засаг захиргаа ажилдаа орсноос хойш Тайваньтай холбогдуулан олон талт дэмжлэг үзүүлсээр ирсэн. АНУ, Японы дээд хэмжээний уулзалтын хамтарсан мэдэгдэл болон АНУ-Япон-БНСУ-ын Гадаад хэргийн сайд нарын хамтарсан мэдэгдэлд Тайваний бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг олон улсын аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтийн зайлшгүй чухал элемент гэж онцолсон, одоогийн байгаа байдлыг нэг талын хүчээр өөрчлөх ямар ч оролдлогыг эсэргүүцэхээ мэдэгдсэн бөгөөд Тайванийг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахыг дэмжиж буйгаа илэрхийлсэн. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Марко Рубиогийн тэргүүтэй олон албаныхан ил тод байдлаар олон удаа энэхүү байр сууриа давтан илэрхийлсэн. Мөн 2025 оны Үндэсний Батлан Хамгаалах Зөвшөөрлийн тухай хууль АНУ-ын Төлөөлөгчдийн танхим болон Сенатаар батлагдаж,



Гадаад хэргийн сайд Лин Жя-лун (зүүн гар талын төвд) 5-р сарын 8-нд Техас мужийн нийслэл Остинд байрлах Техасын Төлөөлөгчдийн танхимд айлчиллаа. (Гадаад хэргийн яамны мэдээ)

хуулийн дагуу баталгаажсан. Уг хуульд Тайваний өөрийгөө хамгаалах чадавхыг бэхжүүлэх заалт багтсан ба АНУ, Тайвань хоёрын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг уриалсан. Хоёр талын хамтын ажиллагааны хүрээ тэлсээр байгаа тул Тайвань-АНУ-ын түншлэл нь дэлхийн хамтын ажиллагааны загвар болж хөгжиж байна.

Латин Америк ба Карибын тэнгисийн 33 орноос Тайвань долоон улстай албан ёсны дипломат харилцаатай: Белиз, Гватемал, Гаити, Парагвай, Сэнт-Китс ба Нэвис, Сэнт-Люсиа, мөн Сэнт-Винсент ба Гренадинс. Тайвань болон түүний Латин Америк ба Карибын холбоотон орнууд маш сайн харилцаатай бөгөөд олон жилийн турш нийгмийн эрүүл мэнд, хөдөө аж ахуй, боловсрол, мэдээлэл, холбоо технологи, ногоон эрчим хүч, аялал жуулчлал,

эмэгтэйчүүдийн эрхийг дэмжих зэрэг салбарт нягт хамтран ажиллаж ирсэн. Эдийн засаг, иргэдийн амьдралд тустай хамтарсан үйл ажиллагаанууд нь ихээхэн амжилт олж, сайнаар үнэлэгдсэн.

Тайвань болон Ватикан олон жилийн дипломат харилцаатай бөгөөд 2025 онд дипломат харилцаа тогтоосны 83 жилийн ой тохиосон юм. Хоёр тал шашны эрх чөлөө, хүмүүнлэгийн тусламжийг дэмжих нийтлэг эрхэм зорилготой. Энх тайван, эрх чөлөө, ардчилал, хүний эрхийг дээдэлдэг нийтлэг үнэт зүйлсээрээ Тайвань нь олон улсад энэрэнгүй үйлс, энх тайвныг дэмжихэд Ромын Пап болон бусад улс орны хамтрагч хэвээр байх болно.

Тайвань ба Европын Холбоо олон салбарт нягт хамтын ажиллагаа, солилцоог хөгжүүлснээр эдийн засаг, худалдааны хүчтэй, идэвхтэй харилцаагаа бэхжүүлж, ногоон эрчим хүч, шинэ технологи, дижитал шилжилт, нийлүүлэлтийн сүлжээний бүтцийн өөрчлөлт зэрэг шинэ сорилтуудад хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. Мөн Тайвань ба Европын Холбоо хүний эрхийн салбарт хамтын ажиллагаагаа тэлж байгаа бөгөөд жил бүр зохион байгуулагддаг Тайвань ба Европын Холбоо хүний эрхийн зөвлөлдөөнөөр хоёр тал хүйсийн тэгш байдал, ЛГБТ-ийн эрх, цагаач ажилчдын эрх зэрэг нийтлэг сэдвээр хамтран ажиллаж байна.

Европын Холбооны 2019-2024 оны бүрэн эрхийн хугацаанд Европын парламент Европын Холбоо болон Тайваний хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэн хөгжүүлэх, Тайваний олон улсын оролцоог дэмжих, Тайваний хоолойд Хятад өдөөн хатгасан үйл ажиллагаанд ихээхэн санаа зовж байгаагаа илэрхийлсэн 40 гаруй тогтоол баталжээ.

Тайвань болон Япон Улс нь худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан ба технологи, соёл, боловсролын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор байгуулсан олон арван хэлэлцээр, санамж бичгийн үндсэн дээр нягт харилцаа холбоотой байдаг. Эдгээр

баримт бичгүүдийг Тайвань-Японы харилцааны холбоо болон Япон-Тайваний солилцооны холбоо хэрэгжүүлдэг.

Японы 2024 оны “Гадаад бодлогын хөх ном”-д Тайванийг “туйлын чухал түнш” хэмээн тодорхойлсон бөгөөд Япон Улс нь Тайваний олон улсын тавцанд оролцоог тууштай дэмждэгийн зэрэгцээ бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд тууштай байр суурьтай оролцогч юм.

Тайвань болон Япон Улс нь хэрэгцээт цаг үед харилцан туслалцаа үзүүлж ирсэн бөгөөд үүний тод жишээ нь 2020 оны COVID-19 цар тахлын үеийн дэмжлэг, мөн 2024 оны 1 дүгээр сард Японы Ното мужид, түүнчлэн тус оны 4 дүгээр сард Тайваний зүүн бүсийн Хуалань тойрогт болсон газар хөдлөлтийн дараах харилцан тусламжийн үйл ажиллагаанууд юм.

Худалдааны харилцааны бат бөх байдал нь жил бүр зохион байгуулагддаг эдийн засаг, худалдааны бага хурал болон хоёр жил тутам хуралддаг Эдийн засгийн түншлэлийн хорооны үйл ажиллагаанаас тод харагддаг. Эдгээр уулзалтууд нь тодорхой хугацааны завсарлагын дараа 2022 онд дахин эхэлсэн юм. Мөн хоёр улс 2024 оны 8 дугаар сард тэнгисийн асуудлаарх жил тутмын уулзалтаа зохион байгуулж, шинжлэх ухааны судалгаа болон тэнгисийн аюулгүй байдлын чиглэлээр цаашдын хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцсэн байна.

2015 оны 11 дүгээр сард Тайвань болон Филиппин Улс загас агнуурын салбарын аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор “Загас агнуурын асуудлаарх хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр”-ийг байгуулсан байна.

2016 оны 7 дугаар сарын 19-нд Ерөнхийлөгч Цай Өмнөд Хятадын тэнгисийн асуудалтай холбоотой дөрвөн зарчим, таван зүйлийг дэвшүүлсэн юм.

Дөрвөн зарчим:

Нэгдүгээрт Өмнөдийн маргаан Хятадын тэнгисийн асуудлыг олон улсын хууль, тэнгисийн хууль, тэр дундаа НҮБ-ын тэнгисийн хуулийн конвенцод нийцүүлэн энхийн замаар зохицуулах ёстой, Хоёрдугаарт Тайвань маргааныг шийдвэрлэхэд чиглэсэн олон талт механизмд хамрагдах ёстой, Гуравдугаарт Холбогдох улс орнууд бүс нутагт агаарын замын аюулгүй байдал болон нислэгийн эрх чөлөөг хангах үүрэгтэй, Дөрөвдүгээрт Санал зөрчилдөөнөөс зайлсхийж, хамтын ажиллагааг дэмжих замаар маргааныг шийдвэрлэх ёстой.

Хэлэлцээр эрх тэгш байдал дээр үндэслэх ба Тайвань бүх улстай Өмнөд Хятадын тэнгисийн энх тайван, тогтвортой байдлыг сайжруулж, бүс нутгийн нөөцийг илрүүлж, хөгжүүлэх тал дээр хамтран ажиллахад бэлэн байна. Харин дэвшүүлсэн таван зүйлд улс орны загас агнуурын эрхийг хамгаалах, олон талт уулзалт зөвлөгөөнд оролцох, шинжлэх ухааны хамтын ажиллагааг сурталчлан дэмжих, далайн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүдийг төлөвшүүлэх зэрэг хүчин зүйлүүд багтана.

Засгийн газар Нанша арал дахь Тайпин арлыг Өмнөд Хятадын тэнгис дэх хүмүүнлэгийн хангамжийн бааз болгон өөрчлөхөөр ажиллаж байна. 2000 онд Тайпин арал болон Дунша арлуудад Засгийн газрын оролцоог хангах үүрэг хүлээсний дагуу Засгийн газрын Далайн хэрэг эрхлэх хорооны дэргэдэх Эргийн хамгаалалтын захиргаа гамшгийн үед хариу арга хэмжээ авч, гадаад дотоодын иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн. Өмнөд Хятадын тэнгисийн амгалан тайван тогтвортой байдлыг дээшлүүлэхэд холбогдох бүх талуудтай хамтран ажиллах Засгийн газрын бодлогын дагуу ойр хөрш орнуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсээр байна.

Тайпин арал нь 0.51 хавтгай дөрвөлжин километр талбайтай бөгөөд хүн ам оршин суух боломжтой, өөрийн гэсэн эдийн засгийн чадамжтай юм. Мөн НҮБ-ын “Далайн эрх зүйн тухай” конвенцын 121 дүгээр зүйлд заасан арлын

стандарт, НҮБ-ын “Далайн эрх зүйн тухай” конвенц дахь Тайваний нутаг дэвсгэрт хамаарагдах далай, зэргэлдээх бүс болон далайн 200 милийн зайд орших эдийн засгийн онцгой бүс, НҮБ-ын ХБХБГ-н дагуу эх газрын тавиурын боломжийг бүрэн хангасан арал юм.

Харилцан ашигтай хамтын ажиллагаа

Тайвань дэлхий дахинд үлгэр жишээ болсон иргэний нийгэм цогцлоосон тул хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, цар тахлыг хянах ажиллагааг цаашид үргэлжлүүлэхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлт, терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоор байх болно.

Ирээдүйд тус улс Засгийн газруудын хамтын ажиллагаа, бизнесийн хөрөнгө оруулалт, ажиллах хүчний солилцоог идэвхтэй байлгах замаар холбоотнууд болон үзэл баримтлал нэгтэй улс орнуудтай урт хугацааны түншлэлийн харилцаа тогтоож, хамтран ажиллан, дэлхий нийтийн энх тайван, эрх чөлөө, ардчилал, хүний эрхийн нийтлэг үнэт зүйлсийг сахин хамгаалж, түгээн дэлгэрүүлэх болно.

2015 онд байгуулагдсан Дэлхий нийтийн хамтын ажиллагаа, сургалтын цар хүрээ нь Тайвань, Америк, Япон, Австрали болон түүний ижил төстэй хамтрагч орнуудын албаныхан болон мэргэжилтнүүд дэлхийн өнгөц бүрээс оролцдог сургалт зохион байгуулахад голлох индэр болж байна. Олон жилийн туршид энэхүү санаачилга нь нийгмийн эрүүл мэнд, хууль сахиулах, кибер аюулгүй байдал, энергийн аюулгүй байдал, хэвлэл мэдээллийн чанар, эмэгтэйчүүдийн эрх мэдэл, гамшгийн үед хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зэргээр энэхүү платформд оролцох орнууд болон шийдвэрлэх асуудлын цар хүрээ улам бүр өргөжиж байна.

Тайвань цар тахлын эсрэг хорио цээрийн дэглэм, тусгаарлалтын горим сахиж, өндөр технологи ашиглан ойрын хавьтагчийг илрүүлэх, мэдээллээ ил тод хуваалцах



Гадаад хэргийн сайд Лин Жя-лун (зүүн гар талд) 2024 оны 4 дүгээр сард Африкийн Холбоот Улс Эсватинийн нийслэл Мбабана хотод тус улсын хаан Мсвати III-тай уулзав. (Гадаад хэргийн яамны мэдээ)

зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ба энэхүү арга хэмжээ нь одоо Тайваний загварчлал нэрээр дэлхий дахинд танигдаад байна. Энэхүү загварчлалын үр дүнг хуваалцах болон 80 гаруй улс орнуудад амны хаалт, эмнэлгийн бусад хэрэгслийг хандивласнаар тус улсад коронавирусний эсрэг вакцин хийх, судлах чиглэлээр холбоотнуудтайгаа нягт хамтран ажиллах үүдийг нээж өгсөн юм.

Амь насыг авран хамгаалж, дэлхийн цар тахлын эсрэг хариу арга хэмжээнд чухал хувь нэмэр оруулсан хэмээн өндрөөр үнэлэгдсэн “Тайваний загвар” нь 2021 онд дотоодын хамгийн хүнд цар тахлын үед бодит сорилттой тулгарсан юм. Нийгмийн бүхий л салбарын түргэн

шуурхай хариу арга хэмжээ болон дотоод, гадаадаас ирсэн вакцины хандивын хандивын ачаар Тайвань COVID-19-ийн эсрэг тэмцэлд амжилттай ялалт байгуулсан. Энэхүү дэмжлэгт тулгуурлан Тайвань нь нийт хүн амын эрүүл мэндийг хамгаалахын төлөө ижил үзэл баримтлал бүхий орнуудтай олон нийтийн эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагаагаа улам бэхжүүлсээр байна.

Нийгэмд гарсан өөрчлөлт, эдийн засгийн либералчлал болон Тайваньд ардчилсан өөрчлөлт гарснаар хувийн хэвшлийнхэнд таатай орчин бий болж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа ихээхэн хөгжсөн юм. Иргэний нийгэм өнөөдрийн сайн засаглалыг бий болгох, Тайванийг олон улсын тавцанд зөөлөн хүчний бодлогыг ашиглах боломжийг олгоход гол үүрэг гүйцэтгэж байна. ТББ-ууд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нягт уялдсан олон улсын хамтын ажиллагааны төрөл бүрийн төслүүдэд оролцож Тайваний нэр хүндийг өсгөж байна. Тайваний ТББ-уудыг олон улс оронтой илүү сайн холбохын тулд Засгийн газар олон улсын хурал зөвлөгөөн, үйл ажиллагаа арга хэмжээнд оролцож туршлага хуримтлуулах, чадвараа дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлдэг. Түүнчлэн Засгийн газар нь олон улсын төрийн бус байгууллагуудыг Тайваньд Төлөөлөгчийн газар байгуулахад нь дэмжлэг үзүүлэхээс гадна ардчилал, аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтийг цаашид түгээн дэлгэрүүлэхэд нь таатай орчноор хангаж өгдөг.

Тайваний ТББ-дыг олон улстай илүү үр дүнтэй холбохын тулд Засгийн газар нь олон улсын хурал, арга хэмжээнд оролцоог дэмжихийн зэрэгцээ байгууллагуудын чадавхыг бүх талаар бэхжүүлэхэд анхаарч байна. Мөн Засгийн газар нь олон улсын ТББ-дыг Тайваньд төлөөлөл, салбараа нээхэд дэмжлэг үзүүлэх хүсэлтэй бөгөөд энэ нь ардчилал, эрх чөлөө, хүний эрх болон хөгжил цэцэглэлтийг улам бүр дэмжихэд таатай орчныг бүрдүүлэх зорилготой юм.

Онцлох мэдээлэл

06

Ерөнхийлөгч Лай Чин Дэгийн “Энх тайвны дөрвөн тулгуур зарчим” нь дараах үндсэн элементүүдийг агуулна.

- Үндэсний батлан хамгаалалтыг бэхжүүлэх;
- Эдийн засгийн аюулгүй байдлыг сайжруулах;
- Далайн эргийн тогтвортой, зарчимч удирдлага хэрэгжүүлэх;
- Үнэт зүйлд тулгуурласан гадаад бодлого баримтлах;

Хоёр эргийн харилцаа

БНХУ-ын Засгийн газар 1949 онд Тайваньд шилжин ирснээс хойш Пэнху, Жиньмэнь, Мазү зэрэг арлууд болон Тайваний мэдлийн дагуул арлуудад бүрэн эрхээ хэрэгжүүлж байх ахуйд Хятад Улс Бээжингийн эрх баригчдын хяналтад байсаар ирсэн. 1980-аад оны сүүлээр ардчилсан нийгэмд шилжсэнээр хоёр эргийн иргэдийн харилцаа болон солилцоонд тавигдсан олон хязгаарлалт цуцлагдсан юм. Түүнчлэн өнөөдрийн байдлаар Тайвань Хятадын хамгийн том хөрөнгө оруулагчдын нэг болоод байна. 1991 оноос 2024 оны 12 дугаар сарын эцэс хүртэл Хятадад оруулсан хөрөнгө оруулалтын тоо нь 45,833 бөгөөд нийт хэмжээ 210.02 тэрбум ам.доллар болоод байна. 2024 онд хоёр эргийг дамнасан худалдааны хэмжээ 176.28 тэрбум ам.долларт хүрсэн.

2008 оны 6 дугаар сард Тайваний хагас албан ёсны байгууллага болох Хоёр эргийн солилцооны сан болон

“Хоёр эргийн солилцооны сан” нь БНХАУ болон БНХУ Тайвань хоёрын хоорондын иргэний болон бизнесийн асуудлыг зохицуулдаг хагас албан ёсны байгууллага юм. (Чин Хун-хао)




Хятадын Хоёр эргийн харилцааны холбоо хоёрын хоорондын албан ёсны хэлэлцээ 10 жилийн завсарлагын дараа дахин эхэлсэн юм. 2015 оны 8 дугаар сар гэхэд Тайваний хоолойн хоёр талд ээлжлэн 11 удаа хэлэлцээр хийж, 23 албан ёсны гэрээ байгуулснаас 21 нь ойлголцолд хүрч хүчин төгөлдөр болсон байна. Эдгээрийн дотроос хамгийн чухал нь 2010 оны 6 дугаар сард байгуулсан Тайвань, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны суурь хэлэлцээр бөгөөд энэ нь Тайвань ба Хятадын хооронд худалдаа, эдийн засгийн харилцааг институцийн түвшинд хэвшүүлэх зорилготой юм.

Энх тайван, тогтвортой байдал

Дотоодын шинэчлэлийг явуулахын тулд тус улсад тайван амгалан, тогтвортой гадаад орчин шаардлагатай. Ялангуяа Хятадтай харилцах харилцааны тал дээр илүү шаардлагатай байна.

Хоёр эргийн худалдаа



Эх сурвалж: Олон улсын худалдааны газар

2024 оны 5-р сарын 20-нд ерөнхийлөгч Лай тангараг өргөхдөө хэлсэн үгэндээ, Тайваний хоолойд энх тайван, харилцан ашигтай, чинээлэг зэрэгцэн орших нь хоёр талын хамтын зорилго байх ёстой гэж онцолжээ.

Ардчилал ба эрх чөлөө нь Тайваний тууштай баримталдаг үндсэн үнэт зүйлүүд бөгөөд урт хугацааны энх тайван, тогтвортой байдлаар дамжин хүрэх хөгжил, бүтээмж бол тус улсын зорилго юм. Засгийн газар ямар нэгэн буулт хийхгүй, өдөөн хатгалга үйлдэхгүй бөгөөд харин хоёр эргийн өнөөгийн байдлыг хадгалж, эрх тэгш байдлын зарчимд нийцсэн эрүүл, зохион байгуулалттай харилцаа, солилцоог сэргээхийг эрмэлзэж байна

Харин сүүлийн жилүүдэд Хятад Улс хоёр эргийн харилцааны талаар улс төрийн байр сууриа илэрхийлж, өөрийн талаас албан ёсны харилцаагаа таслан, Тайваньд удаа дараа улс төр, цэргийн дарамт шахалт үзүүлсэн билээ. 2019 оны 1 дүгээр сарын 2-нд Хятад Улс Тайваньд “Нэг улс, хоёр систем”-ийн загварыг судлахыг санал болгосноор бүс нутгийн амгалан тайван, тогтвортой байдлыг алдагдуулж байна.

2022 онд АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын дарга Нэнси Пелоси Тайваньд айлчилсны дараа ерөнхийлөгч Цай дараагийн спикер Кэвин Мкартитэй уулзав. Энэхүү хоёр үйл явдлын дараа Хятадын эрх баригчдын зүгээс Тайваньд улс төр, эдийн засаг, цэрэг армийн дарамт шахалтыг улам хүчтэй үзүүлэх болов.

Геополитикийн хурцадмал байдлыг намжаах үүднээс Засгийн газар Тайваний бүс нутаг болон Хятадын эх газрын ард түмний хоорондын харилцааг зохицуулах хуулийг шинэчилж байна. Өнөөдрийг хүртэл батлагдсан нэмэлт өөрчлөлтүүд нь хоёр эргийн улс төрийн хэлэлцээрт ардчилсан хяналтын механизмыг бий болгосон бөгөөд Хятадын зөвшөөрөлгүй хөрөнгө оруулалтад торгууль ногдуулахаар зохицуулсан.

Түүнчлэн үндэсний аюулгүй байдалтай холбогдох гол технологи эзэмшдэг, Засгийн газраас судалгааны буцалтгүй тусламж авсан этгээдийг Хятадад аялахыг хязгаарлах, хяналтыг нэмэгдүүлэх, Хятадын аж ахуйн нэгжүүд гуравдагч этгээдээр дамжин Тайваньд хууль бусаар бизнес эрхлэхээс сэргийлэх хуулийн зохицуулалт хийгдсэн.

Ерөнхийлөгч Лай Чиндэгийн хоёр эргийн бодлогын зарчим, чиглэлийн дагуу хоёр эргийн харилцааг хөгжүүлэх асуудлыг Засгийн газар нухацтай авч үзэх болно. Нийгмийн бүх салбарын дуу хоолойг сонсож, хоёр эргийн солилцооны удирдлагын механизмыг бэхжүүлж, ардчилал, аюулгүй байдлын хамгаалалтын механизмыг боловсронгуй болгож, шаардлагатай үед хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. Энэ нь хоёр эргийн хоорондох эерэг харилцааг дэмжих, хоёр талын солилцоог хэвийн, тогтвортой байлгах зорилготой юм.

Тогтвортой хандлага

Засгийн газар цаашид хоёр эргийн харилцааг Тайваний Үндсэн хууль, Тайваний бүс нутаг болон Хятадын эх газрын ард түмний хоорондын харилцааг зохицуулах тухай хууль болон ард түмний хүсэл зоригийн үндсэн дээр тулгуурлан зохицуулна.

Засгийн газар Бээжингийн эрх бүхий байгууллагуудад БНХУ Тайваний оршин тогтнолын бодит байдлыг хүлээн зөвшөөрч, Тайваний ард түмэн өөрсдийн сонгосон хууль ёсны засгийн газартай харилцах эрхийг хүндэтгэхийг уриалж байна. Хятад Улс сөргөлдөөний оронд яриа хэлцлийг, хязгаарлахын оронд солилцоог сонгож, энх тайван, харилцан хөгжил цэцэглэлтийг эрхэмлэж, тэгш эрх, нэр төртэй байх зарчмыг баримтлахыг уриалж байна.

Засгийн газар Хятадын Коммунист Нам улс төр, цэргийн дарамтаа зогсоож, бүс нутгийн энх тайван, тогтвортой

байдлыг хамгаалах дэлхий нийтийн өмнө хүлээсэн хариуцлагыг Тайваньтай хуваалцах ёстойг олон удаа мэдэгдэж ирсэн.

ХКН-ын заналхийллийг үл харгалзан Тайвань эрх чөлөө, ардчиллын үнэт зүйлсийг хамгаалж, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хамгаалах энх тайвны дөрвөн тулгуурт үйл ажиллагааны төлөвлөгөөг идэвхтэй сурталчлах болно. Тайваний холбогдох хууль, дүрэм, Үндсэн хуульд заасны дагуу хоёр эргийн эрүүл, дэг журамтай солилцоог дэмжих болно. Үүнд: Үндэсний бүрэн эрхт байдлыг хамгаалах; Тайвань хоолойн энх тайван, тогтвортой байдлыг хадгалах; Эрх тэгш, нэр төрийн зарчимд тулгуурлан хоёр талын эрүүл, зохион байгуулалттай хэлэлцээ, солилцоог явуулах; Тайваний ардчилсан, эрх чөлөөт амьдралын хэв маягийг хамгаалах.

Мөн үүний зэрэгцээ Засгийн газар Энхийн дөрвөн тулгуур зарчим болон үндэсний аюулгүй байдлын гол сорилтуудад хариу үзүүлэх 17 стратегийг хэрэгжүүлсээр байх болно.

Засгийн газар Хятадын зүгээс Тайваньд үзүүлж буй заналхийллийг сөрөн зогсох, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийг дэмжих, үндэсний эрх ашгийг хамгаалахын тулд АНУ, Япон болон бусад ижил төстэй ашиг сонирхол бүхий улс орнуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн гүнзгийрүүлэх болно.

Онцлох мэдээлэл

07

2024 онд Тайвань бүтээгдэхүүн экспортлогч дэлхийн 16 дахь орноор шалгарсан.

Өмнөдөд чиглэсэн шинэ бодлогын хүрээнд Тайвань Зүүн өмнөд Азийн орнуудын холбооны гишүүн 10 улс, Өмнөд Азийн 6 улс, Австрали, Шинэ Зеланд зэрэг улс орнуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлж байна.

Эдийн засаг

Тайвань дэлхийн эдийн засагт чухал байр суурийг эзэлдэг. Дэлхийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын шилдэг тоглогч төдийгүй үйлдвэрлэлийн салбарын голлох бүтээгдэхүүний томоохон нийлүүлэгч юм.

Дэлхийн худалдааны байгууллагын мэдээлснээр 2024 онд Тайвань 16 дахь экспортлогч болон импортлогч орноор тодорсон. 2024 оны 12 дугаар сарын байдлаар гадаад валютын хамгийн их нөөцтэй орны нэгээр шалгарав. ОУВС-ийн тайлангаар 2025 оны 4-р сарын байдлаар Тайваний ДНБ-ий нэг хүнд ногдох хэмжээ 34,430 ам.долларт хүрчээ. ДНБ-ий хувьд Тайвань нь Швейцарь, Польштой ойролцоо эрэмбэлэгддэг бол нэг хүнд ногдох ДНБ-ий худалдан авах чадвараараа Дани, Нидерланд Улстай төстэй байна.

Биотехнологи нь Тайваний "Таван нэмэх хоёр шинэчлэлт үйлдвэрлэл"-ийн төлөвлөгөөний хүрээнд хурдацтай өсөлтөд чиглэсэн салбаруудын нэг юм. (Чин Хун-хао)



Худалдааны өсөлт

2024 онд инфляцийн бууралтаас гадна хүүгийн төвшин буурснаар дэлхийн худалдаа сэргэжээ. Хиймэл оюун ухаан, өндөр гүйцэтгэлт тооцоолол болон бусад инновацлаг технологийн хэрэглээнээс үүдэлтэй шинэ боломжуудаас ашиг олсон Тайваний нийт худалдааны хэмжээ 2024 онд 869.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны үзүүлэлтээс 10.9 хувиар өссөн байна. Экспорт 9.8 хувиар, импорт 12.2 хувиар нэмэгдсэн.

Олон улсын менежментийн хөгжлийн институт болон Business Environment Risk Intelligence зэрэг байгууллагуудаар жил бүр явагддаг дэлхийн эдийн засгийн судалгаанд Тайвань урт хугацааны өсөлт болон технологийн хөгжилд тэргүүлэгч орнуудын нэгээр тогтмол жагсаж байна. 2025 онд зарласан үр дүнг “Дэлхийн судалгааны жагсаалт” (хуудас 64–65) хэсэгт үзүүлжээ.

2013 оны 7 дугаар сард Тайвань Шинэ Зеланд улстай Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурснаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн улстай анх удаа гэрээ байгуулсан юм. Мөн оны 11 дүгээр сард Сингапур Улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан нь Тайвань нь Зүүн өмнөд Ази дахь худалдааны түнш улстайгаа анх удаа гэрээ байгуулсан хэрэг юм. Дээрх хоёр гэрээ нь Дэлхийн худалдааны байгууллагын (WTO) стандартаас давж гарсан юм. Ийнхүү ахиц гарснаар Тайваний Номхон далайн бүсийн иж бүрэн, ахисан түвшний түншлэлийн гэрээ (CPTPP) болон Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэлийн гэрээ (RCEP) зэрэг бүс нутгийн эдийн засгийн интеграцийн механизмд оролцоог дэмжихэд чиглэгдсэн юм.

ДНБ 2024 он


Номинац: **US\$797 тэрбум**

Нэг хүнд ногдох хэмжээ (номинац):

US\$34,040


Нэг хүний худалдан авах чадвар (ОУВС):

US\$76,860



Тайвань мөн 2017, 2018, 2019, 2020 онд Парагвай, Эсватинийн вант улс, Маршаллын арлууд, Белиз улстай эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ. Эдгээр гэрээ нь эдийн засаг, хөрөнгө оруулалт, технологи, худалдааны харилцааг

Эдийн засгийн өсөлтийн үзүүлэлт



Эх сурвалж: Төсөв, нягтлан бодох бүртгэл, статистикийн ерөнхий газар

бэхжүүлэхийн зэрэгцээ дээрх улстай найрамдалт харилцаагаа бататгах зорилготой юм.

Тайвань, АНУ 2023 оны 6-р сард 21-р зууны худалдааны Тайвань-АНУ-ын санаачилгын хүрээнд анхны хэлэлцээрт гарын үсэг зурсан. Мөн талууд нийлүүлэлтийн сүлжээний хамтын ажиллагаа, эрчим хүчний шилжилтийг эрчимтэй хөгжүүлсэн.

Тайвань-АНУ-ын эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн түншлэлийн яриа хэлэлцээ, Тайвань-АНУ-ын технологийн худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа. 2024 оны 2-р сарын 22-нд хоёр улс олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурснаар Тайвань АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүгийн корпорацитай хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын боломжийг хангах хамтын ажиллагааг ахиулсан.

Хөгжлийн чиг хандлага

Тайвань 2016 оноос шинээр аж үйлдвэр хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн нь өөрчлөлт шинэчлэлийг хурдасгаж өгсөн. 5+2 аж үйлдвэрлэлийн инновацийн төлөвлөгөө нь дараагийн үеийн ухаалаг машин механизм, Азийн цахиурын хөндий, биотех эм зүй, ногоон эрчим хүч, батлан хамгаалах, шинэ хөдөө аж ахуй, тойрог эдийн засгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд гол хүчин зүйл болсон юм.

2020 онд урд өмнө нь явуулж байсан бодлого дээрээ тулгуурлан зургаан цөм стратегийн үйлдвэрлэлийг байгуулсан бөгөөд энэ нь 2019 оны Тайваний гурван том төлөвлөгөөтэй холбогдож хөрөнгө оруулалт хийгдсэн. Үүнд мэдээлэл ба дижитал технологи; кибер аюулгүй байдал; нарийвчилсан анагаах ухааны технологи; батлан хамгаалах; ногоон, сэргээгдэх эрчим хүч болон стратегийн нөөц үйлдвэрлэл зэрэг багтана. Эдгээр нь Тайваний аж үйлдвэрийн хөгжлийг ахиулж хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгоно.

Засгийн газар нь ирээдүйн 30 жилийн хугацаанд хөгжүүлэх “Дэд бүтцийн хөгжлийн хэтийн төлөв” хөтөлбөрийг дэмжин ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр нь төмөр замын хөгжил, дижитал дэд бүтэц, усан орчин, хүнсний аюулгүй байдал, ногоон эрчим хүч, хот орон нутгийн хөгжил, төрөлт, хүүхэд асрах байгууламжийг

Худалдаа, хөрөнгө оруулалтын танилцуулга (2024)

Худалдааны нийт хэмжээ: **US\$869.4 тэрбум**




Экспорт: **US\$475 тэрбум**




Импорт: **US\$394.4 тэрбум**

Худалдааны тэнцвэрт байдал:
US\$80.6 тэрбум ам.долларын ашигтай

Экспортын том түнш орон (нийт экспортын %-иар):




Импортын том түнш орон (нийт импортын %-иар):



Гадаад валютын нөөц: **US\$576.67 тэрбум**
(2024 оны 12-р сарын байдлаар)

Бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ:
US\$44.93 тэрбум


Эхний таван орон



Бүртгэлтэй дотоодын хөрөнгө оруулалт:

US\$7.8 тэрбум

Эхний таван орон



Дэлхийн судалгааны зэрэглэл			
Судалгааны сэдэв (хэвлэгдсэн огноо)	Зэрэглэл	Судалгаанд хамрагдсан орнууд	Судалгааны байгууллага
Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан (2025 оны 6-р сар)	6	69	Олон улсын менежментийн хүрээлэн
Эдийн засгийн эрх чөлөөний индекс (2025 оны 3-р сар)	4	184	Өв сан

нэмэгдүүлэх, авьяас чадварыг сайшаах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг үндсэн найман бодлогыг агуулж байна.

Шинэлэг үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ засгийн газар байгаль орчныг хамгаалахад тууштай анхаарал хандуулж байна.

Шинэ эдийн засгийн загвар нь аж үйлдвэрийн бүтцийн шинэчлэлт, газар ашиглалтын дахин төлөвлөлт, бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихийн зэрэгцээ ногоон эрчим хүчний нөөцийг ашиглахыг зорьж байна.

Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт, хөгжлийг ухаалаг технологи болон тогтвортой байдлаар бэхжүүлэх зорилгоор 2024 онд Засгийн газар таван гол итгэл даах үйлдвэрлэлийн салбарт анхаарлаа төвлөрүүлсэн бөгөөд үүнд хагас дамжуулагч, хиймэл оюун ухаан, цэргийн салбар, аюулгүй байдал ба хяналт, шинэ үеийн харилцаа холбооны технологи орно. Мөн жижиг, дунд үйлдвэрүүдийг шинэчлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Хиймэл оюун ухаан бий болж, үйлдвэрлэлийн дижитал болон цэвэр тэг өөрчлөлтийн сорилтуудын хариуд засгийн газар Азийн Цахиурын хөндийн төлөвлөгөөний одоо байгаа суурь дээр үндэслэн Азийн Цахиурын хөндийн хөгжлийн төлөвлөгөө 3.0-ыг санал болгов. Энэ нь дижитал болон цэвэр нүүрстөрөгчийн үйлдвэрлэлийн шилжилтийг хурдасгахын тулд хиймэл оюун ухаан, 5G болон хиймэл дагуулын сүлжээ зэрэг технологийн хөгжилд анхаарлаа хандуулах тухай ойлголт юм. Ингэснээр ирэх дөрвөн жилийн хугацаанд гарааны бизнесүүдийн санхүүжилтийг өргөжүүлэх боломжтой юм.

Энэхүү арга замаар Засгийн газар дэлхийн хэмжээнд тулгарч буй сорилтууд болон удаан үргэлжилсэн АНУ-Хятадын худалдааны зөрчилдөөнийг намжаахын зэрэгцээ цалингийн түвшинг нэмэгдүүлж, бүс нутгийн хөгжлийг ахиулах зорилготой юм. Энэхүү арга хэмжээ нь аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, Тайваний эдийн засгийг улам хүчирхэгжүүлэх болно.

Онцлох мэдээлэл

08


Тайвань нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч орны нэг юм.

2025 оны 6 дугаар сард гаргасан Олон улсын менежментийн хөгжлийн хүрээлэнгийн Дэлхийн эдийн засгаар өрсөлдөх чадвартай 69 орны жагсаалтын 6 дугаарт Тайвань багтсан байна.

Шинжлэх ухаан, технологи

Тайванийг шинэлэг, хүртээмжтэй, тогтвортой болгох зорилготой “Ухаалаг Тайвань 2030 алсын хараа”-г хэрэгжүүлэхийн тулд Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл нь тус улсын нийт хүн амын харилцан адилгүй хэрэгцээг ойлгож тодорхойлох үүднээс бусад яамдтай хамтран судалгаа хийж байна. Мөн шинэлэг технологийг өдөр тутмын амьдралд нэвтрүүлж, байгальд ээлтэй шинэ үйлдвэрүүд байгуулах боломжийг нээж өгөх зорилготой юм. Шинжлэх ухаан, технологи нь эдийн засгийн өсөлт, үндэсний хөгжлийн гол хөдөлгөгч хүч бөгөөд Тайваний Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл нь гарааны бизнесийг дэмжих, үндэсний шинжлэх ухааны гурван том паркийг сурталчлах, шинжлэх ухааны судалгааг дэмжих замаар хөгжүүлэхийг зорьж байна. Мөн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, судалгааны ажлыг үйлдвэрлэлийн хэрэгцээнд чиглүүлэх олон арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Тайвань нь хагас дамжуулагч (integrated circuits)-ийн томоохон үйлдвэрлэгч бөгөөд эдгээр нь дэвшилтэт технологийн хөгжлийн чухал үүрэг гүйцэтгэдэг. (Чин Хун-хао)



Тайваний өндөр технологийн компаниудын амжилт нь Засгийн газраас үзүүлж буй дэмжлэгтэй үлэмж холбоотой юм. Үйлдвэрлэлийн технологийн судалгааны хүрээлэн, Үндэсний хэрэглээний судалгааны лаборатори, Мэдээлэл үйлдвэрлэлийн судалгааны хүрээлэн зэрэг байгууллагууд Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйлдвэр, технологи судалгаа эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэдэг.


Инновацыг дэмжих нь

Үйлдвэрлэлийн технологийн судалгааны хүрээлэн (ITRI)-ийн мэргэшлийг түүний шагналууд тодорхой харуулдаг. Сүүлийн 17 жилийн хугацаанд тус байгууллага 66 R&D 100 шагнал, 2017 оноос хойш 23 Edison шагнал, мөн 2015 оноос хойш 9 Clarivate Top 100 Global Innovator шагнал хүртжээ. Мөн тус хүрээлэн нь дэлхийн зах зээлд амжилттай орж чадсан компаниудыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэдний дунд Taiwan Semiconductor Manufacturing Co. болон United Microelectronics Corporation зэрэг байгууллагууд орж, хагас дамжуулагчийн үйлдвэрлэлд дэлхийн хэмжээнд тэргүүлэгчдийн нэгээр нэрлэгддэг.

2003 онд байгуулагдсан Үндэсний Хэрэглээний Судалгааны Лаборатори (NIAR) нь 2025 оны 3 дугаар сар хүртэл Үндэсний хэрэглээний судалгааны лабораториуд нэрээр олонд танигдаж байсан бөгөөд NSTC-ийн харьяа бие даасан ашгийн бус байгууллагад долоон үндэсний лабораторийг нэгтгэсэн байна.

Шинэ нэрийн дор NIAR нь үндсэн зорилтуудаа үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үүнд судалгаа, хөгжүүлэлтийн (R&D) платформ байгуулах, академик судалгааг дэмжих, мэдлэгийн шинэ хязгаарт шинжлэх ухаан, технологийг сурталчлах, өндөр технологийн боловсон хүчин бэлтгэх зэрэг багтана.

Тайваний гурван том технологийн паркийн аж ахуйн нэгжүүдийн худалдааны эргэлт (2024)



Эх сурвалж: Үндэсний шинжлэх ухаан Технологийн консул

Үндэсний лабораторийн үүрэгтээ тулгуурлан NIAR нь засгийн газрын бодлого, дэлхийн чиг хандлагатай уялдан инновацийг тэргүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна. Тус институт нь одоогийн шинжлэх ухааны судалгааны чиглэлд үндэслэн олон салбарын интеграц, шинэ технологийн хөгжлийг эрэлхийлдэг.

Байгаль орчин, нийгмийн өөрчлөлтөд хариу үзүүлэх чиглэлд хагас дамжуулагч, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал, нисгэгчгүй тээврийн хэрэгсэл, “тэг нүүрстөрөгчийн ялгаруулалт” технологи болон биотехнологи зэрэг салбарууд орно. NIAR нь судалгаа, хөгжүүлэлтийн (R&D) платформыг бий болгож, шинэ

Дэлхийн судалгааны зэрэглэл			
Судалгааны сэдэв (хэвлэгдсэн огноо)	Зэрэглэл (ангилал)	Судалгаанд хамрагдсан улс орнууд	Судалгааны байгууллага
Дэлхийд өрсөлдөх чадварын жилийн тайлан (2025 оны 6-р сар)	10 (технологийн дэд бүтэц) 5 (Шинжлэх ухааны дэд бүтэц)	69	Олон улсын менежментийн хөгжлийн хүрээлэн
Дэлхийд өрсөлдөх чадварын тайлан (2019 оны 10-р сар)	4 (инновацийн чадвар)	141	Дэлхийн эдийн засгийн форум

технологийг нэвтрүүлэх замаар үндэсний хөгжилд хувь нэмэр оруулахад тууштай анхаарч ажиллаж байна.

Мэдээллийн аж үйлдвэрийн хүрээлэнгийн (III) зорилго нь дижитал шилжилтийг дэмжих платформыг бий болгох замаар Тайваний дэлхийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх явдал юм.

Энэхүү институт нь инновацлаг мэдээлэл, харилцаа холбооны технологийн бүтээгдэхүүн, хэрэглээний судалгаа, хөгжүүлэлтийг (R&D) явуулдаг. Бодлого боловсруулах болон мэргэжилтэн бэлтгэх төв (think tank) байдлаараа төр, хувийн хэвшлийн ICT хөгжлийг дэмжих чухал үүрэг гүйцэтгэдэг. Сүүлийн 40 жилийн хугацаанд III нь 500,000-аас дээш мэргэжилтнийг сургалтад хамруулсан байна.

Тайваний технологийн экосистем нь Ази тивд өөрийн байр сууриа эзлэхээр зорьж буй гадаадын

хөрөнгө оруулагчдад тохиромжтой орчин бүрдүүлдэг. Технологийн хөгжүүлэгчид, инженерийн үйлчилгээ үзүүлэгчид, орон нутгийн хөрөнгө оруулалтын компаниуд нь хамтарсан технологийн инновацид гүн мэдлэг, туршлагыг авчирдаг. Энэ сэтгэлгээг Taiwan Tech Arena тусгасан бөгөөд энэ нь дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн амбицтай стартапуудыг татдаг динамик төв юм.

Тайпэй болон Тайнан хотод салбаруудтайгаар үйл ажиллагаа явуулдаг ТТА нь стартап экосистемийг дэмжихийн тулд акселераторууд, хөрөнгө оруулагчид болон салбарын тэргүүлэгчдийг нэгтгэдэг. Энэ нь орон нутгийн болон дэлхийн технологийн компаниудыг хөгжихөд трамплин (шууд эхлэл тавих тавцан) болж ажилладаг.

Онцлох мэдээлэл

09

Тайваньд 140 их, дээд сургууль, коллеж, ахлах сургууль үйл ажиллагаа явуулдаг.

Хос хэл 2030 бодлого нь мандарин хятад болон англи хэлний ур чадварыг дээшлүүлж, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийг зорьж байна.

Боловсрол

Боловсрол нь төрийн бодлогын салшгүй хэсэг бөгөөд төсвийн ихэнх хувийг зарцуулдаг. Дээд боловсрол эзэмших явдлыг тусгайлан дэмжсэнээр техникийн коллеж, их дээд сургууль төгссөн хүмүүс Тайваний нийт хүн амын 50.6 хувийг эзэлж, сүүлийн 10 жилийн хугацаанд 7.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Боловсролын яамнаас оюутнуудад илүү боломж олгох үүднээс 2014 оноос эхлэн зайлшгүй эзэмших есөн жилийн суурь боловсролын тогтолцоог 12 жил болгон хэрэгжүүлж байна. Тайваний оюутан залуус жил бүр биологи, хими, газар зүй, математик, мэдээлэл зүй, физикийн олон улсын уралдаан тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байруудыг эзэлж байна. Тайваний чадварлаг боловсон хүчний нөөц нь тухайн улсын

Засгийн газрын удирдлагатай хүүхэд асрах төвд цэцэрлэгийн насны хүүхдүүд анхан шатны боловсролын хөтөлбөрийн хүрээнд чулуу будаж байна. (Чин Хун-хао)



эдийн засгийн хөгжил цэцэглэлт, амьдралын чанарыг дээшлүүлэхэд асар өндөр хувь нэмэр оруулдаг билээ.

Засгийн газар нь 12 жилийн суурь боловсролын тогтолцоонд Тайваний нутгийн уугуул иргэдийн 16 омгийн хэл, хакка, холо зэрэг хэлийг дахин сэргээхийн тулд зайлшгүй судлах хичээлүүдийн тоонд оруулсан байна. Цаашлаад Тайваний авьяас чадвар, үйлдвэрлэлийн дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газар 2021 оноос “Хос хэл 2030” (хятад, англи хэл) бодлогыг хэрэгжүүлж байна.

Спортын яам нь 2025 оны 9 дүгээр сард үүсгэн байгуулагдсан бөгөөд биеийн боловсролыг хөгжүүлэх, спорттой холбоотой үйл ажиллагааг зохицуулах, иргэдийн оролцоог дэмжих, спортын салбар болон спортын дипломатиар дамжуулан эрүүл, идэвхтэй нийгмийг бүрдүүлэх зорилготой ажилладаг.

Тэтгэлэгт хөтөлбөрүүд

Гадаад оюутнууд Тайваний Засгийн газрын болон их дээд сургуулийн тэтгэлэгт хамрагдах боломжтой. Тухайлбал, Тайваний тэтгэлэгт хөтөлбөр нь бакалавр, магистрт суралцах хүсэлтэй оюутнуудад тэтгэлэг олгодог. Тэтгэлэгийг сонирхож буй залуус тус улсын элчин сайдын яам, төлөөлөгчийн газартай холбоо барих эсвэл Боловсролын яамны <https://english.moe.gov.tw/lp-24-1.html> веб сайтаар мэдээлэл авч болно.

Боловсролын яам мөн Тайваньд олон улсын оюутнуудыг Мандарин хэл сурах, Тайваний соёл, нийгмийг судлахыг дэмжих зорилгоор Huayu Enrichment Scholarship тэтгэлэгийг бий болгосон. Энэхүү хөтөлбөр нь гадаад оюутнуудад улсын хэмжээнд 65 их, дээд сургуулийн харьяа хэлний төвд Мандарин хэлний курсуудыг судлах боломж олгодог.

Тоо баримт

15 ба түүнээс дээш насны: **99.3%**  (2024)

Боловсрол, соёл, шинжлэх ухааны төсөв:




Улсын нэгдсэн төсвийн **19.3%** (2025)

Дээд боловсролын байгууллагууд: **140** 
(128 их дээд сургууль, коллеж, 12 ахлах коллеж)

Их дээд сургуульд суралцаж буй оюутнуудын тоо:

Нийт: **1.07 сая**



Магистрын хөтөлбөрт: **177,888**

Докторын хөтөлбөрт: **28,816**
(2024)

Мандарин сургалтын төвүүдийн жагсаалт болон Тайваньд хэл сурахтай холбоотой бусад мэдээллийг дараах вэбсайтуудаас үзэж болно:

- Боловсролын яам,
- Study in Taiwan: www.studyintaiwan.org,
- Taiwan Mandarin Educational Resources Center: https://lmit.edu.tw/en/school_list

Онцлох мэдээлэл

10

Тайвань нь хятад үндэстний поп хөгжмийн гол төв юм.

Тайпэй хотын Хааны ордон музей нь эртний Хятадын түүх дурсгалын үзмэрүүд хадгалагдаж байдаг алдартай музей юм.

Тайвань нь уламжлалт болон орчин үеийн соёл урлагийг гайхалтай хослуулсан орон юм. Үндэсний түүх, соёлыг сурталчлахын тулд Хааны ордон музей, Тайваний үндэсний музей, Үндэсний түүхийн музей, Эртний түүхийн музей, Тайваний үндэсний утга зохиолын музей, Тайваний Дүрслэх урлагийн музейг тус тус байгуулжээ. Улсын хэмжээнд Үндэсний дуурийн театрын концертын танхим, Тайжун хотын Үндэсний театр, Гаосюн хотын Үндэсний урлагийн төв, Тайваний уламжлалт урлагийн төв зэрэг томоохон төвүүдийг байгуулсан.

Тайваний Илань хот дахь Үндэсний уламжлалт урлагийн төвд байрлах Лу Пин-чэнгийн бүтээсэн аварга том баримлыг хулс болон Хакка даавуугаар урласан. (Чен Мэй-линг)

Соёл



Тайванийг Азийн урлаг соёлын томоохон төв болсныг илтгэх Олон улсын урлагийн их наадам, Тайпэй хотын урлагийн наадам зэрэг арга хэмжээнүүд эдгээр соёл урлагийн төвүүдэд зохион байгуулагддаг. Уламжлалт уран барилгын сонгодог загварыг сүм хийд, албан байгууллага, түүх дурсгалын барилгуудад тусгасан байдгаас гадна хуучны барилга байгууламжуудыг сэргээн засварлан кафе, бэлэг дурсгалын дэлгүүр болгон өргөн ашиглаж байна. Хятад үндэстний уламжлалт урлаг, гар урлал, ёс заншил Тайваньд бусад Хятад газраас сайн хадгалагдан үлдсэн байдаг. Жишээлбэл, Тайвань бол Хятадын уламжлалт ханзыг ашигладаг цөөхөн газрын нэг бөгөөд уран бичлэгийн уралдаан байнга өргөн цар хүрээтэй зохион байгуулагдаж байдаг.

Сүм хийдийн баяр ёслол, утга зохиол, дүрслэх урлаг, тайзны урлагт Буддизм, Күнз, Даоизмын уламжлалт сургаалыг зохих хэмжээгээр хадгалсаар байна. Нэмж дурдахад жуулчид тус улсын хакка, холо болон 16 уугуул иргэдийн өв уламжлалтай танилцах боломжтой бөгөөд Тайваний гадаад улс дахь төлөөлөгчийн газрын соёлын хэлтэс нь өөрийн орны баялаг соёлын өвийг дэлхийн бусад улс үндэстэнд танилцуулан сурталчилж байдаг.

Үүний зэрэгцээ Тайваний томоохон хотуудад 24/7 цагийн турш ажилладаг үзвэр үйлчилгээний газрууд олон бий. Тайванийг Мандопоп буюу хятад поп хөгжмийн нийслэл гэж үздэг. Саяхан үүд хаалгаа нээсэн Тайпэй хотын Хөгжмийн төв, Гаосюн хотын Хөгжмийн төв аль аль нь мэргэжлийн тоглолт болдог гол газар аль хэдийн болжээ. Сүүлийн жилүүдэд орон нутагт кино урлаг, орон нутгийн телевиз эрчимтэй хөгжиж байна. Мөн гар урлалын салбар нийгэмд байр



Уран дархан уламжлалт дэнлүүнд сүүлийн чимэглэлийг хийж байна. (Чэнь Мэй-лин)

сууриа аль хэдийн эзэлснийг жил бүр нэмэгдэж буй загвар зохион бүтээгчдийн зах дэлгүүр, үзэсгэлэн худалдаанаас харж болно.

Утга зохиол, урлаг, ардын уламжлалт баяр наадмаас эхлээд шөнийн захуудын хөл хөдөлгөөн, уур амьсгал хүртэл Тайваний уламжлалт өдөр тутмын амьдралтай нягт уялдаатай бөгөөд өнгөрсөн үе нь өнөө үеийн эрч хүч, гүн гүнзгий байдлын эх сурвалж нь болж цэцэглэн хөгжиж буй соёлын өнгийг нэмдэг.

Онцлох мэдээлэл

11

Хил хязгааргүй сэтгүүлчид
байгууллагын тодорхойлсноор
Дэлхийн хэвлэл мэдээллийн эрх
чөлөөний индексээр Тайвань Ази
тивд нэгдүгээрт жагсжээ.

Хэвлэл мэдээлэл

Тайваний хэвлэл мэдээллийн олон ургалч байдал нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, салбарын ширүүн өрсөлдөөн дундаас тодрон гарч ирж байна. Тус улсын хэвлэл мэдээллийн салбар нь Ази тивдээ нийгмийн хамгийн чөлөөт орчинд ажилладаг.

2025 оны Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс-т Тайвань дэлхийд 24-р, Азидаа 1-р байранд жагссан бөгөөд энэхүү судалгааг Францад төвтэй “Хил хязгааргүй сэтгүүлчид” байгууллагаас 2025 оны 5 дугаар сарын 2-нд зарласан юм. Нийт 180 орон, бүс нутгийг хамарсан энэхүү судалгаанд Тайвань нь Өмнөд Солонгос, Япон, Хонгконг болон Хятадаас тэргүүлсэн байна.

Ерөнхийлөгч Лай Чин-дэг (урд, баруун талаас хоёр дахь) орон нутгийн хоёр хэвлэл мэдээллийн агентлагийн ажилтнуудтай хамт селфи зургаа авхуулж байна. (Ерөнхийлөгчийн тамгын газар)



Зураглал



Радио
станц:
186



Шугамын
кабелийн
телевиз:
5



Хиймэл
дагуулын
өргөн
нэвтрүүлгийн
үйлчилгээ
үзүүлэгчид:
133
(296 суваг)




Кабелийн
телевизийн
операторууд:
63

(2025 оны статистик)

Эх сурвалж: Харилцаа холбооны үндэсний хороо

Айл өрхийн телевизийн тоон системд шилжсэн байдал



Эх сурвалж: Харилцаа холбооны үндэсний хороо



Цэцэглэн хөгжиж буй бие даасан номын дэлгүүрүүд нь Тайваний хэвлэл мэдээллийн орчны салшгүй хэсэг юм. (Чин Хун-хао)

2024 оны 6 дугаар сарын байдлаар, 22 орны 84 хэвлэл мэдээллийн байгууллагын нийт 176 сэтгүүлч Тайваньд ажиллаж байна.

Ихэнх хэвлэл мэдээллийн салбарын хэмжээнд дижитал шилжилтийг хийж байна. Тайваний мэдээлэл, харилцаа холбооны технологийн давуу талыг ашиглан цахим хэвлэл хурдацтай хөгжиж орон нутагт ном сэтгүүл хэвлэх тоо нэмэгдэж байна. 2024 оны 1-8 дугаар сард нийт 36,174 шинэ ном хэвлэгдсэн байна.

Кабелийн телевиз тоон системд шилжсэнээр дүрс гаралтын чанар эрс сайжраад зогсохгүй илүү шинэлэг, олон төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг бий болгож, олон талт мэдээллийн эх үүсвэрийн чөлөөт индэр болж чадсан.

Онцлох мэдээлэл

12

62-оос цөөнгүй улс, бүс нутгийн иргэд Тайваньд 14, 30 эсвэл 90 хоног визгүй зорчих боломжтой.

Тайвань нь 24 цагийн туршид аяллын мэдээллийг олон хэлээр өгдөг лавлах утас ажиллуулдаг (0800-011-765).

Тайваний аялал жуулчлал

Өвөрмөц соёл, үзэсгэлэнт байгаль, олон төрлийн хоол, их хотын хөгжөөнтэй амьдрал, өргөн хэрэглээний үйлчилгээний салбар өндөр хөгжсөн тул Тайвань жуулчдын анхаарлыг зүй ёсоор татдаг.

Тайваньд ойролцоогоор 1,100 км уламжлалт төмөр замын шугам байгаагаас гадна баруун эрэг дагуу 350 км хурдны төмөр замын систем ажилладаг. Өндөр хурдны галт тэрэг нь Тайпэй Гаосюн хотын хооронд 94 минут зорчино. Эдгээр хоёр хот болон Тайваний хойд бүсэд байрлах Таюань хот болон Тайчун хот нь мөн сүүлийн үеийн хамгийн хурдан нийтийн тээврийн системд холбогдсон.

Өндөр хурдны галт тэрэгний шугам болон уламжлалт төмөр замууд нь Шиньчү зэрэг газарт холбогддог бөгөөд тэдгээрийн сүлжээ нь ижил өртөөнд байрладаг. (Чин Хун-хао)



Тайваньд хэдэн зууны турш цайны тариалалтаар хуримтлуулсан туршлага бий бөгөөд одоо технологийн дэвслээр улам боловсронгуй болж, экспорт болон дотоодын хэрэглээнд зориулсан өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. (Жимми Лин)



Олон улсын үзэсгэлэн худалдаа

Тайваний Гадаад Худалдааны Хөгжлийн Агентлаг нь жилийн туршид олон салбарыг хамарсан үзэсгэлэнг зохион байгуулдаг. Тайпэй хотын Дэлхийн худалдааны

төвийн үзэсгэлэнгийн танхим, Нанганий үзэсгэлэнгийн танхим, Гаосюн хотын үзэсгэлэнгийн танхим зэрэг томоохон төвүүд байдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг www.taiwantradeshows.com.tw веб сайтаас авна уу.

Жуулчдад зориулсан ерөнхий мэдээлэл

Засгийн газраас гадаадын иргэдийг Тайваньд аялах, амьдрах, ажиллах талаарх мэдээллээр хангах зорилгоор жуулчдад зориулсан олон тооны веб сайт, лавлах утас ажиллуулдаг.

Вэб сайт/Шууд утас

Гадаад хэл

Тайваний аялал жуулчлалын газар
www.taiwan.net.tw

Хятад, Англи, Франц, Герман, Индонези, Япон, Солонгос, Малайз, Испани, Тайланд, Вьетнам хэл

Аялал жуулчлалын мэдээллийн шууд утас
0800-011-765 (24 цаг)

Англи, Япон, Солонгос, Хятад хэл

Гадаадын иргэн, харьяатын газар
www.immigration.gov.tw

Англи, Индонези, Кхмер, Хятад, Тайланд, Вьетнам хэл

24 цаг:
Англи, Япон, Хятад хэл

Гадаадын иргэдэд зориулсан мэдээллийн шууд утас 0800-024-111

Ажлын өдрүүдэд
9:00-17:00: Вьетнам хэл
Ажлын өдрүүдэд
13:00-17:00: Индонез, Кхмер, Тайланд хэл

Аялал жуулчлалын гол газрууд

Тайваний хойд бүс

Хааны ордон музей: www.npm.gov.tw

Тайпэй 101: www.taipei-101.com.tw

Шинэ Тайпэй хотын Ингэ шаазан ваарны музей:
www.ceramics.ntpc.gov.tw

Чан Кайшигийн үндэсний дурсгалын танхим:
www.cksmh.gov.tw

Луншань сүм: www.lungshan.org.tw

Шэйпа үндэсний цэцэрлэгт хүрээлэн:
www.spnp.gov.tw

Янмин уулын үндэсний цэцэрлэгт хүрээлэн:
www.ymsnp.gov.tw

Зүүн хойд эрэг болон Иланы эргийн байгалийн
үзэсгэлэнт газар: www.necoast-nsa.gov.tw

Хойд эрэг ба Гуанинь уулын байгалийн үзэсгэлэнт
газар: www.northguan-nsa.gov.tw

Тайваний төвийн бүс

Нар сар нуурын байгалийн үзэсгэлэнт газар:
www.sunmoonlake.gov.tw

Формоса арлын нутгийн уугуул иргэдийн соёлын
тосгон: www.nine.com.tw

Саншаны байгалийн үзэсгэлэнт газар:
www.trimt-nsa.gov.tw

Тайваний үндэсний гар урлал судлал, хөгжлийн
хүрээлэн: www.ntcri.gov.tw

Луган хотхон: www.lukang.gov.tw

Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей:
www.nmns.edu.tw

Юй шань (Хаш уул) үндэсний цэцэрлэгт хүрээлэн:
www.ysnp.gov.tw



Тайваний зүүн бүс

Тароко үндэсний цэцэрлэгт хүрээлэн:
www.taroko.gov.tw

Тайваний ойн бүсийн амралт зугаалгын газар:
recreation.forest.gov.tw

Зүүн эргийн байгалийн үзэсгэлэнт газрууд:
www.eastcoast-nsa.gov.tw

Зүүн хэсгийн судал хөндийн байгалийн үзэсгэлэнт газрууд:
www.erv-nsa.gov.tw

Тайваний өмнөд бүс

Тайжъян үндэсний байгалийн цогцолбор газар:
www.tjnp.gov.tw

Кеньдиний үндэсний цэцэрлэгт хүрээлэн: www.ktnp.gov.tw

Алишань уулын байгалийн үзэсгэлэнт газар:
www.ali-nsa.net

Сираяа байгалийн үзэсгэлэнт газар: www.siraya-nsa.gov.tw

Дапэн булангийн байгалийн үзэсгэлэнт газар:
www.dbnsa.gov.tw

Маолины байгалийн үзэсгэлэнт газар:
www.maolin-nsa.gov.tw

Баруун өмнөд эргийн байгалийн үзэсгэлэнт газар:
www.swcoast-nsa.travel.gov.tw

Шоу шань байгалийн үзэсгэлэнт газар: www.nnp.gov.tw

Эрэг дагуух арлууд

Жиньмэн үндэсний цэцэрлэгт хүрээлэн: www.kmnp.gov.tw

Өмнөд Пэнху далайн байгалийн үзэсгэлэнт газар:
www.marine.gov.tw

Мазү байгалийн үзэсгэлэнт газар: www.matsu-nsa.gov.tw

Ногоон арал ба цахирмаа цэцгийн арал:
tour.taitung.gov.tw/en/discover/offshore-islands



Чухал баяр наадам, арга хэмжээнүүд

Сар	Үйл ажиллагаа*
I сар	Шинэ жилийн баяр
II сар	Тайваний дэнлүүний баяр**
III сар	Тайваний цахирмаа цэцгийн олон улсын шоу
IV сар	Тайжун хотын Мазу олон улсын наадам (зан үйл, мөргөл) Дапэн эргийн урлагийн наадам Тайпэй хувцас загварын 7 хоног
V сар	Пэнху олон улсын салют буудуулах наадам
VI сар	Зүүн эргийн орон нутгийн урлагийн наадам (Сарны гэрэл-далайн эргийн урлагийн тоглолт)
VII сар	Тайваний олон улсын агаарын бөмбөлгийн баяр
VIII сар	Тайваний хоолны үзэсгэлэн
IX сар	Тайваний унадаг дугуйны баяр
X сар	Нар сар нуурын дугуйн аялал, хөгжим салютны баяр
XI сар	Тайваний PASIWALI наадам Гаиллардиа арлууд Пэнху далайг гатлах марафон
XII сар	Тайваний халуун рашаан ба тансаг хоолны наадам Шинэ Тайпэй хотын Зул сарын баяр

Тайваний төвд байрлах Чанхуа хотын Лукаан тосгоны Тяньхоу сүм нь далайн бурхан Мазу-д зориулсан ариун сүм юм. (Чин Хун-хао)



* Дэлгэрэнгүй мэдээллийг Аялал жуулчлалын газрын eng.taiwan.net.tw веб сайтаас авна уу!

** Тайваний дэнлүүний баяр жил бүр өөр хот, Сяньд зохион байгуулагддаг. 2025 онд Таюянь хотод зохион байгуулагдана.

Үндэсний мөнгөн тэмдэгт

Шинэ тайвань доллар (NT\$ эсвэл TWD)
Валютын ханш: 1 ам.доллар тутамд NT\$32.3
(2024 оны 6 дугаар сар)

Цагийн бүс

Бүх нутаг дэвсгэр нэг цагийн бүсэд багтдаг,
UTC+8 цаг (улирал хамаарахгүй)

Кредит карт болон аялагчийн чек

Кредит картуудыг өргөнөөр ашигладаг. Аялагчид
банк зочид буудал, жуулчдад зориулсан бэлэг
дурсгалын дэлгүүрт бэлэн мөнгө солиулж болдог.

Цайны мөнгө өгөх

Тайваньд цайны мөнгө өгөх заншил байдаггүй.
Зочид буудлын өрөөний үнэ, зоогийн газрын хоолны
төлбөрт 10 хувийн үйлчилгээний хөлс багтсан
байдаг.

Цахилгаан

AC 110 V / 60 Hz

Визний мэдээлэл

ГХЯ-ны Консулын Газрын
Утас: (+886)-2-2343-2888
Веб сайт: www.boca.gov.tw

Гаалийн дүрэм

Гаалийн Ерөнхий Газар, Сангийн Яам
Утас: (+886-2) 2550-5500 ext. 2116
Вэб сайт: web.customs.gov.tw



2025-2026

ТАЙВАНИЙГ нэг цонхоор